



## ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Ерөнхий дүгнэлт ЗАСАГЛАЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ТОДОРХОЙ БОЛГОХ,  
АУДИТЫН ХАМРАХ ХУГАЦААНД 1,476.1 САЯ ТӨГРӨГИЙН АШИГТАЙ АЖИЛЛАСАН  
ХЭДИЙ Ч САНХҮҮГИЙН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАНГАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН  
ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

АУДИТЫН КОД: ОРА-2022/22-13-ШТА-ТД



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.

**Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор  
Ц.Нармандах**

Утас: 70353888 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

**Аудитын менежер**

Утас: 70355805 Цахим хаяг:

**Ахлах аудитор Г.Оргилмөрөн**

Утас: 70350757 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn

**Аудитор Б.Азжаргал**

Утас: 70350757 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn

**Аудитор Г.Даваасүрэн**

Утас: 70350757 Цахим хаяг: davaasureng@audit.gov.mn

## АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар .....	3
Хүснэгтийн товъёг .....	4
<b>БҮЛЭГ 1. ТӨРИЙН ӨМЧИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТӨРИЙН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ХАНГАЛТГҮЙ НЬ ТОДОРХОЙ БУС БАЙДЛЫГ ҮҮСГЭЖ, ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛЖ БАЙНА.</b> .....	6
А.1. Төрийн өмчит компанийн засаглалын талаарх эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байна. ....	7
А.2 Төрийн өмчийн хуулийн этгээдийн компанийн засаглалыг хөгжүүлэх бодлого орхигдсон, эрх зүйн зохицуулалт дутмаг, засаглалын тогтолцоонд ТУЗ-ийн үйл ажиллагаа үр нөлөөгүй байна. ....	8
<b>БҮЛЭГ 2. ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮД 2019-2021 ОНД НИЙТ 1,476.1 САЯ ТӨГРӨГИЙН АШИГТАЙ АЖИЛЛАСАН Ч САНХҮҮГИЙН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ БҮРЭН ХАНГАЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.</b> .....	10
Б.1 Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн зорилтот түвшнийг өмнөх онуудын гүйцэтгэл, эрх бүхий этгээдээс өгсөн чиглэлд үндэслэн төлөвлөж, ТУЗ болон хувьцаа эзэмшигчдээс хянуулан зохих өөрчлөлтийг тусгаж, баталж байна. ....	10
Б.2 Төрийн өмчит хуулийн этгээдийн орлого зорилтот түвшнийг хангасан боловч Орхон АЗЗА ТӨХК татварын хуримтлагдсан өр төлбөртэй байна. ....	12
Б.3 Санхүүгийн үйл ажиллагаанд Орхон АЗЗА ТӨХК нь үр ашгийн тооцоо хийж, үр нөлөөг дүгнээгүй, санхүүгийн харьцаа үзүүлэлтийг бүрэн хангаагүй хэдий ч түүвэрт хамрагдсан байгууллагууд аудитын хамрах хүрээний хугацаанд эдийн засгийн зорилтот түвшнийг хангаж, нийт 1,476.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. ....	13
Б.4. Үйл ажиллагааны зардлыг батлагдсан зорилтот түвшний хүрээнд хэмнэлттэй зарцуулсан боловч зарим үр ашиггүй зардал гаргасан байна. ....	17
<b>БҮЛЭГ 3. БҮХИЙ Л ХЯНАЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.</b> .....	22
В.1. Хөндлөнгийн хяналтаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлын хүрээнд холбогдох арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлсэн байна. ....	22
В.2 Холбогдох зохицуулалтын хүрээн дэх дотоод хяналтуудад үр дүнгийн үнэлэлт хийгээгүй байна. ....	23
В.3 Мэдээллийн ил тод байдлыг шилэн дансны тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлж байна. ....	24
<b>ДҮГНЭЛТ: ЗАСАГЛАЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ТОДОРХОЙ БОЛГОХ, АУДИТЫН ХАМРАХ ХУГАЦААНД 1,476.1 САЯ ТӨГРӨГИЙН АШИГТАЙ АЖИЛЛАСАН ХЭДИЙ Ч САНХҮҮГИЙН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАНГАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.</b> .....	25
<b>ХАВСРАЛТУУД:</b> .....	26

### Товчилсон үгийн тайлбар

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АЗЗА	Авто зам засвар арчлалт
АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МШӨ	Мэргэжлээс шалтгаалах өвчин
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
САА	Сангийн аж ахуй
ТНДБ	Төрийн нарийн бичгийн дарга
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТХХХ	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа
УИХ	Улсын Их Хурал
ҮХЭХАТ	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ШБАЗ	Шинэ бүтээл ашигтай загвар
ЭДЦС	Эрдэнэтийн дулааны цахилгаан станц
ЭХ	Эргэлтийн харьцаа
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ЭХЯ	Эрчим хүчний яам

## Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ЭДЦС ТӨХК-д хийсэн засаглалын үнэлгээ	6
Хүснэгт 2	Орлогын гүйцэтгэл	11
Хүснэгт 3	Сүүлийн 3 жилийн хугацаанд төлсөн татвар, хураамж	12
Хүснэгт 4	ЭДЦС ТӨХК-ийн удирдлагын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	16
Хүснэгт 5	Орхон АЗЗА ТӨХК-ийн удирдлагын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	16
Хүснэгт 6	Орон тоо, цалингийн төлөвлөгөө, гүйцэтгэл – ЭДЦС ТӨХК	17

## Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Төлөөлөн удирдах зөвлөл хуралдсан тоо	8
График 2	Баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний өөрчлөлт – ЭДЦС ТӨХК	10
График 3	Баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний өөрчлөлт – Орхон АЗЗА ТӨХК	10
График 4	Сүүлийн 5 жилийн тайланд үндэслэн хийсэн санхүүгийн эрсдэлийн түвшин – ЭДЦС ТӨХК	13
График 5	Сүүлийн 5 жилийн тайланд үндэслэн хийсэн санхүүгийн эрсдэлийн түвшин – Орхон АЗЗА ТӨХК	13
График 6	Төлбөрийн чадварын шинжилгээ.	14
График 7	Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ – ЭДЦС ТӨХК	15
График 8	Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ – Орхон АЗЗА ТӨХК	15
График 9	Батлагдсан орон тоо, нийт цалингийн гүйцэтгэл – Орхон АЗЗА ТӨХК	20

**АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

**Аудитын зорилго**

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашигт улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй эсэх;
- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх;
- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй эсэх;

**Аудитын хамарсан хүрээ**

Аудитад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компанийн тухай хууль, УИХ, Засгийн газраас гаргасан тогтоол, тухайн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд төрийн өмчит 2, орон нутгийн өмчит 6 хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтыг хэрэгжүүлэхэд оролцогч хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, аймгийн ИТХ, Засаг дарга, ЗДТГ, ОНӨГ зэргийн 2019-2021 оны үйл ажиллагааг хамрууллаа.

**Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР 3910, УДИР 3920, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, МУЕА-ын баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудаас тайлбар, тодруулга, судалгаа авч, шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж, аудитын асуудлын шинжилгээ, аудитын загварын матриц, аудитын горимыг хэрэгжүүлэн нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын бүрэлдэхү үн, хугацаа**

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, ахлах аудитор В.Жавзмаа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Оргилмөрөн, аудитор Б.Бямбатогтох, Т.Болормаа, Б.Азжаргал, Г.Даваасүрэн, О.Хэрлэнзаяа нар 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

**Аудитын явцад учирсан хүндрэл, бэрхшээлүүд:**

Аудитын явцад хүндрэл, бэрхшээл үүсээгүй болно.

## Ерөнхий мэдээлэл

### ЭДЦС ТӨХК

ЭДЦС ТӨХК-ийн эхний ээлж 1987 оноос ашиглалтад орж цахилгаан, дулаан үйлдвэрлэж эхэлснээс хойш 35 дахь жилдээ Эрдэнэт хотын ард иргэдийг дулаан, цахилгаан эрчим хүчээр тасралтгүй, найдвартай ханган ажиллаж байна.

ЭДЦС ТӨХК нь 7 зуух, 3 турбинтэй, цагт 302.5 Гегакалори/цаг дулаан, 28,8 Мегаватт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх чадалтай бөгөөд 1 алба, 5 хэлтэс, 8 цехийн зохион байгуулалттай, 450 хүнтэйгээр, 24 цаг тасралтгүй үйл ажиллагаа явуулан ажиллаж байна.

ЭДЦС ТӨХК нь жилд дунджаар 163.3 сая кВтц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэн 133.6 сая кВтц цахилгаан эрчим хүч түгээж, 604,4 мян.Гкал дулааны эрчим хүч боловсруулан 580,8 мян.Гкал дулааны эрчим хүч түгээж байна.

Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу БНХАУ-ын Засгийн газраас олгох 51.8 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр “Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх СС50-3.43/1.27/0.25 МВт-ын турбингенератороор өргөтгөх” төслийг 2019 онд эхлүүлж, 2021 онд бүрэн ашиглалтад оруулжээ.

Дээрх СС-35 МВт-ын турбогенераторын өргөтгөл ашиглалтад орсноор 35-48 МВт-ын ачааллыг эрчим хүчний системд нийлүүлэх боломжтой болж ЭДЦС ТӨХК нь 71 МВт-ын суурилагдсан чадалтай, 67 МВт төслийн хүчин чадалтай, 3-4 МВт нөөц чадал авах нөхцөл бүрдэж цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг 2.4 дахин өсгөж, нэгж бүтээгдэхүүний өөрийн өртгийг бууруулж байна.

### Орхон АЗЗА ТӨХК

Эрдэнэт хотын Зам анги нь 1979 онд Хот хоорондын авто тээврийн 35-р баазын харьяа замын хэсэг нэртэйгээр анхны сууриа тавьж, 1982 оны 01 дүгээр сарын 01-ны өдөр “Эрдэнэт хотын зам барилга ашиглалтын анги” өрх тусгаарлан “Дархан-Эрдэнэтийн 108 км, Хялганатын 65 км, Эрдэнэт-Булганы 30 км хайрган хучилттай замын засвар арчлалт, хотын төвийн доторхи зам, Ингэттолгойн САА-н Ургац тээврийн зам, Атарын САА-н Хулстайн гурван давааны ургацын замыг арчилж байх үүрэгтэй ажиллаж байжээ.

1994 оноос 2006 он хүртэл бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөд орж явсаар Төрийн өмчийн хорооны 2006 оны 640 дүгээр тогтоолоор Орхон АЗЗА ТӨХК нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Орхон АЗЗА ТӨХК нь Дархан-Эрдэнэтийн чиглэлийн А-1001 дугаартай 108 км улсын чанартай авто зам, Эрдэнэт-Булганы чиглэлийн А-1002 дугаартай 29,7 км хатуу хучилттай авто замуудын засвар арчлалтыг хариуцан Ерөнхий инженер, Геодези ХАБЭА-н инженер, материалын инженер, механик инженер зэрэг дээд болон тусгай мэргэжлийн 39 ажиллагсадтайгаар ажиллаж байна.

**БҮЛЭГ 1. ТӨРИЙН ӨМЧИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТӨРИЙН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ХАНГАЛТГҮЙ НЬ ТОДОРХОЙ БУС БАЙДЛЫГ ҮҮСГЭЖ, ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛЖ БАЙНА.**

**А.1. Төрийн өмчит компанийн засаглалын талаарх эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байна.**

**1.1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд компанийн засаглалын талаарх зохицуулалт тусгагдаагүй байна.**

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдлага, засаглал нь компанийн тухай хуулийн дагуу зохицуулж байна.

Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын компанийн засаглал, төлөөлөн удирдах зөвлөл, эдгээртэй холбогдсон харилцааг бүрэн зохицуулаагүй байна.

Компанийн засаглалыг хөгжүүлэх асуудлыг төрийн болон орон нутгийн өмчит компанийн чиг үүрэг, зохион байгуулалтын хэлбэр, хэмжээнээс хамаарч үйл ажиллагааны цар хүрээнд тохирсон журмаар зохицуулах нь зүйтэй байна.

ЭДЦС ТӨХК, Орхон АЗЗА ТӨХК-ууд нь компанийн хэлбэрийн хувьд адилхан боловч Компанийн тухай хуулиар зохицуулсан харилцаа нь Орхон АЗЗА ТӨХК-ийн хувьд хэрэгцээ шаардлага бага байна.

**1.1.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн компанийн засаглалыг үнэлэх нь сайн дураар хийх зохицуулалттай тул ЭДЦС ТӨХК, Орхон АЗЗА ТӨХК-д засаглалын үнэлгээ хийгээгүй байна.**

Монгол Улсын Засгийн газраас 2011 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 69 тоот тогтоолоор “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Тус хөтөлбөрийн 3 дугаар зорилтын 2 дахь заалтад “Хувьцаа эзэмшигчийн эрхийг баталгаажуулах, хувьцаат компанийн засаглалд хөндлөнгийн үнэлгээ, хяналт, шалгалт хийх, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах механизмыг бий болгох”, 4 дэх заалтад “Компанийн засаглалын төвшний үнэлгээ хийх, олон нийтэд мэдээлэх тогтолцоо бий болгох” гэж тус тус тусгасан байдаг.

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам”-д нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит компаниуд засаглалын үнэлгээг сайн дурын үндсэн дээр хийлгэж болохоор зохицуулсан.

ЭДЦС ТӨХК, Орхон АЗЗА ТӨХК-д дээрх журмын зохицуулалтын хүрээнд засаглалын үнэлгээ хийгдээгүй байна.

Аудитаар компанийн засаглалын үнэлгээний аргачлалын хүрээнд боловсруулсан 6 үзүүлэлт бүхий 102 асуултаар ЭДЦС ТӨХК-д үнэлгээ хийсэн.

Асуулт бүрийн хүрээнд хийгдвэл зохих ажлын хэрэгжилтийг 0-2 оноогоор үнэлж түүнийгээ хувьд шилжүүлэн, үнэлгээг 0-100 хувиар тооцож гаргасан болно.

Энэхүү асуултууд нь хувьцаат компанийн зайлшгүй баримтлах ёстой сайн засаглалын нийтлэг зарчим, Монгол Улсын Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Компанийн засаглалын кодексийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг үнэлэх зорилготой.

ЭДЦС ТӨХК-д хийсэн засаглалын үнэлгээ.

Хүснэгт №1

№	Үзүүлэлт	Авбал зохих нийт оноо	Үнэлгээний оноо	Үнэлгээний хувь
А	Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал	40	23	57.5%
Б	Хувьцаа эзэмшигчдийн ижил тэгш байдал	16	6	37.5%

В	Оролцогч талуудын харилцаа	20	15	75.0%
Г	Мэдээллийн ил тод, нээлттэй байдал	20	12	60.0%
Д	Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх хороод	56	26	48.2%
Е	Гүйцэтгэх удирдлага	20	8	40.0%
	<b>Нэгдсэн дүн</b>	<b>172</b>	<b>91</b>	<b>52.9%</b>

(Үнэлгээний дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс)

ЭДЦС ТӨХК-ийн нэгдсэн үнэлгээ нь 52.9 хувьтай дунд засаглалтай буюу удирдлагын үйл ажиллагаанд асуудал үүсэж болзошгүй дүгнэлттэй байна.

Нэгдсэн үнэлгээний оноог бууруулж буй гол шалтгаан нь холбогдох дүрэм журмын зохицуулалт, хэрэгжүүлэлттэй холбоотой байна.

### 1.1.3. Эрх бүхий байгууллага хууль, эрх зүйн хүрээнд чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 9 дэх заалтын дагуу Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-аар төрийн өмчит компанийн хувьцааны хувь эзэмшлийг тогтоосон байна.

ЭДЦС ТӨХК-ний хувьцаа эзэмшигчийн эрхийг Засгийн газрын 2018 оны 335 тоот тогтоолоор 2018 оноос хойш ЭХЯ-70%, ТӨБЗГ-30%, Орхон АЗЗА ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг ТӨБЗГ-100 хувь тус тус эзэмшиж байна.

ЭДЦС ТӨХК-ний хувьд 2002-2015 онд ЭХЯ-49%, СЯ-20%, ТӨБЗГ-31%, 2016-2017 онд ТӨБЗГ-100 хувь тус тус эзэмшиж байжээ.

Компанийн тухай хуулийн 76.1.13<sup>1</sup>, 80.4<sup>2</sup> болон компанийн дүрэмд заасан журмыг Орхон АЗЗА ТӨХК-ийн ТУЗ-аас батлан гаргаагүй байна.

ЭДЦС ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2012 оны 16 дугаар тогтоолоор баталсан "Үйл ажиллагааны журам"-ын 7.6-д "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь сарын ажлын үр дүнгээр хавьцаа эзэмшигчийн хурлаас баталсан цалингаар цалинжиж, жилийн ажлын үр дүнгээр компанийн ажиллагсдын нэгэн адил урамшуулал авна. Мөн "Хамтын гэрээ"-нд заасан тэтгэмж тусламжид хамрагдана" гэж тусгасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12-д "төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно" гэсэн зохицуулалттай нийцэхгүй байна.

## A.2 Төрийн өмчийн хуулийн этгээдийн компанийн засаглалыг хөгжүүлэх бодлого орхигдсон, эрх зүйн зохицуулалт дутмаг, засаглалын тогтолцоонд ТУЗ-ийн үйл ажиллагаа үр нөлөөгүй байна.

### 1.2.1. Төрийн өмчийн хуулийн этгээдийн компанийн засаглалыг хөгжүүлэх бодлого орхигдсон, эрх зүйн зохицуулалт дутмаг байна.

Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 69 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд тус хөтөлбөрөөр нэгдүгээр үе шатыг 2011-2012 онд, хоёрдугаар үе шатыг 2013-2016 онд хэрэгжүүлэхээр тусгагджээ.

Тус хөтөлбөрийг шинэчлэн боловсруулаагүй, компанийн засаглалыг хөгжүүлэх талаар бодлого орхигдсон, эрх зүйн зохицуулалт дутмаг байна.

<sup>1</sup> Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх 76.1.13.төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах,

<sup>2</sup> Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал. 80.4.Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагааныхаа журмыг тогтоож батлах ...


**1.2.4. ТУЗ нь хуулийн шаардлагад нийцэж сар бүр хуралдаагүй, гүйцэтгэх удирдлагад өгсөн бодлого, шийдвэрийнхээ үр нөлөөг хянаагүй байна.**

ЭДЦС ТӨХК-ийн ТУЗ нь хурлаар хэлэлцэх асуудлаа гарган төлөвлөж төлөвлөгөөний дагуу хуралдаж асуудлыг хэлэлцэн тухай бүр тогтоол шийдвэр гарган ажилладаг байна. Гаргасан тогтоол шийдвэрийг Гүйцэтгэх удирдлага холбогдох журмын зааврын дагуу баримт бичгийг боловсруулан, ажлын төлөвлөгөө гарган ажилладаг байна.

Компанийн тухай хуулиар ТУЗ-ийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хурал хийх зохицуулалттай буюу жилдээ багадаа 12 удаа хуралдах ёстой байна.

ЭДЦС ТӨХК, Орхон АЗЗА ТӨХК-ийн ТУЗ-ийн 2019-2021 оны хооронд хуралдсан тоог графикаар харуулбал.

График №1



ТУЗ-ийн гишүүд сар бүр тухайн сард хуралдсан эсэхээс үл хамааран хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон цалинг тогтмол авч байна.

ЭДЦС ТӨХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга 2020 онд, Орхон АЗЗА ТӨХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга 2021 онд тус тус солигдсон бөгөөд 2019, 2020 оны зарим хурлын тэмдэглэл, холбогдох материалыг аудитын багт ирүүлээгүй, хурлын тэмдэглэлд гишүүдийн гарын үсгийг зуруулаагүй, өмнөх нарийн бичгийн дарга нарийн ажлыг хүлээлцүүлж холбогдох баримт материалыг бүрэн хүлээж аваагүй байна.

ЭДЦС ТӨХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга шинээр томилогдсоноор 2021 оны хурлын тэмдэглэлд гишүүдийн гарын үсгийг зуруулсан байх бөгөөд Орхон АЗЗА ТӨХК-ийн 2021 оны хурлын тэмдэглэлд ТУЗ-ын дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж баталгаажуулсан хэвээр байна.

## **БҮЛЭГ 2. ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮД 2019-2021 ОНД НИЙТ 1,476.1 САЯ ТӨГРӨГИЙН АШИГТАЙ АЖИЛЛАСАН 4 САНХҮҮГИЙН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ БҮРЭН ХАНГАЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.**

**Б.1 Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн зорилтот түвшнийг өмнөх онуудын гүйцэтгэл, эрх бүхий этгээдээс өгсөн чиглэлд үндэслэн төлөвлөж, ТУЗ болон хувьцаа эзэмшигчдээс хянуулан зохих өөрчлөлтийг тусгаж, баталж байна.**

### **2.1.1.Төрийн өмчит хуулийн этгээдүүд өмнөх онуудын гүйцэтгэл, эрх бүхий этгээдээс өгсөн чиглэлд үндэслэн эдийн засгийн зорилтот түвшнийг төлөвлөж байна.**

Төрийн өмчит хуулийн этгээдүүд нь эдийн засгийн зорилтот түвшний ирэх оны төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэл, тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэл, эрх бүхий байгууллагаас тогтоосон үнэ тариф, хүчин чадал, салбар яамнаас ирсэн чиглэлд үндэслэн боловсруулж тогтсон байна.

Тухайлбал: Орхон АЗЗА ТӨХК-ийн хувьд ЗТХЯ, Зам, тээврийн хөгжлийн төвийн хяналтын инженерүүдтэй замын урьдчилсан үзлэг хийж хийгдэх ажлын судалгааг гаргах, аймгийн хариуцуулах зам засварын ажлын төсөвт үндэслэн, ЭДЦС ТӨХК-ийн хувьд техник эдийн засгийн төлөвлөгөөг боловсруулах тусгайлан баталсан журмынхаа хүрээнд ирэх онд тавьж буй зорилготой уялдуулан гүйцэтгэлд үндэслэн эдийн засгийн зорилтот түвшнийг төлөвлөж байна.

Боловсруулсан төлөвлөгөөг ТУЗ болон холбогдох этгээдүүдэд танилцуулж өгсөн чиглэл, зөвлөмжийн өөрчлөлтийг тусгаж эцэслэн боловсруулж байна.

Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн өртөг, үнийн өсөлтийг давахааргүй батлагдсан үнэ тарифаар тооцсон зорилтот түвшний төлөвлөлт үндэслэлтэй болж чадахааргүй байна.

ЭХЗХ-ны 2018 оны 221 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх журам”-аар эрчим хүчний үнэ тарифыг жилд 4 хүртэл удаа индексжүүлэх боломжтой боловч Орхон аймгийн дулааны эрчим хүчний үнэ тариф 2019 оноос хойш өөрчлөгдөөгүй нь Эрчим хүчний тухай хуулийн 9.1.4-т<sup>3</sup> заасан ЭХЗХ-оос индексжүүлэлтийг хэрэгжүүлэх бүрэн эрхээ хангаагүй байна.

Үнэ тарифыг өөрчлөхгүй барьж байгаа нь үйлдвэрлэл нэмэгдэх тутам алдагдал нэмэгдэж, санхүүгийн эх үүсвэр дутагдаж, үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангахад хүндрэл үүсгэхээр байна.

### **2.1.2.Төрийн өмчит хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшнийг эрх бүхий байгууллагаас хянаж шаардлагатай өөрчлөлтүүдийг тухай бүр хийж батлуулахаар хүргүүлдэг байна.**

Төрийн өмчит компанийн боловсруулсан эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөний төслийг ТУЗ-аар, дулааны станцын хувьд ЭХЯ, ТӨБЗГ, ЭХЗХ-ний хамтарсан ажлын хэсгээр хэлэлцээд шаардлагатай өөрчлөлтийг оруулж дэмжиж, холбогдох эрх бүхий байгууллагад батлуулахаар хүргүүлдэг байна.

Тухайлбал ЭДЦС ТӨХК-ийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг ТУЗ, ажлын хэсгээр хэлэлцэн зөвшилцөж орлогыг 127.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, зардлыг 182.9 сая төгрөгөөр бууруулж, 2021 онд орлогыг 4,701.9 сая, зардлыг 5,588.1 сая төгрөгөөр тус тус бууруулж өөрчлөлт оруулан баталсан байна.

<sup>3</sup> Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйл.Зохицуулах хорооны бүрэн эрх.


9.1.4. тариф тогтоох аргачлал боловсруулах, тарифын бүтэц тодорхойлох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифыг хянаж батлах, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх”

### 2.1.3.Төрийн өмчит хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшнийг эрх бүхий байгууллага хянаж баталдаг байна.

Төрийн өмчит хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшнийг батлах эрх бүхий байгууллага нь холбогдох тооцоолол, төслийг боловсруулахад өгсөн чиглэл, ирэх оны зорилготой уялдуулан хянаж батлан, баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захиралд чиглэл өгч байна.

ЭДЦС ТӨХК-ийн техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг 2020 онд 2 удаа 2021 онд 1 удаа тодотгож баталсан байна.

Баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнээс нийт орлого, нийт зардал, ашиг/алдагдлын үзүүлэлтийн 2019-2021 оны өөрчлөлтийг доор үзүүлбэл:



(Батлагдсан техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний шинжилгээг хавсралт №2-оос)

ЭДЦС ТӨХК-ний 2019 оны нийт орлогыг 38,112.0 сая, нийт зардлыг 40,510.9 сая, алдагдлыг 2,398.8 сая төгрөгөөр тус тус баталсан бөгөөд дээрх графикаас харахад 2020 онд нийт орлогыг 4,452.9 сая, нийт зардлыг 2,054.1 сая төгрөгөөр өмнөх оноос нэмэгдүүлэн алдагдлыг тэг төгрөг байхаар тооцож баталжээ.

Харин 2021 онд өмнөх оноос нийт орлогыг 4,117.7 сая, нийт зардлыг 10,241.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, алдагдлыг 6,124.1 сая төгрөгөөр өсгөсөн нь 2019 онд эхэлсэн БНХАУ-ын Засгийн газраас олгох 51.8 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр “Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх СС50-3.43/1.27/0.25 МВт-ын турбингенератороор өргөтгөх” төслийг 2021.09.03-нд ашиглалтад хүлээн авсантай холбоотой байна.

Ингэснээр цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг 35 МВт-аар нэмэгдүүлж, нэгж бүтээгдэхүүний өөрийн өртгийг бууруулсан хэдий ч ЭХЗХ-оос баталсан үнэ тарифын хүрээнд алдагдал ихээр нэмэгдсэн байна.

Орхон АЗЗА ТӨХК-ийн хувьд 2021 онд өмнөх оноос нийт орлогыг 179.9 сая, нийт зардлыг 149.9 сая, ашгийг 30.0 сая төгрөгөөр, 2020 онд өмнөх оноос нийт орлогыг 172.2 сая,

нийт зардлыг 171.7 сая, ашгийг 0.5 сая төгрөгөөр буюу 2021 онд 2019 оноос нийт орлогыг 352.1 сая, нийт зардлыг 321.6 сая, ашгийг 30.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж баталсан байна.

Орлого нэмэгдсэн шалтгаан нь 2021 онд улсын чанартай АЗЗА-ын орлогыг, 2020 онд бусад орлогыг нэмэгдүүлж баталсантай холбоотой байна.

Улсын чанартай АЗЗА-ын орлого 2020 онд 1,098.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 2021 оны төлөвлөгөөг 1,121.0 сая төгрөгөөр тооцож батлуулсан боловч 2021 онд ЗТХЯ-тай байгуулсан гэрээний хүрээнд гүйцэтгэл 978.1 сая төгрөг болж тухайн онд орлогын төлөвлөгөө тасарч 89.7 хувийн биелсэн нь нийт орлогынхоо дийлэнх хувийг бүрдүүлдэг ЗТХЯ-тай байгуулах гэрээний орлогоо бодитой тооцоогүй холбоотой байна.

ЭДЦС ТӨХК-ийн нийт ажилчдын тоо 2020 онд 9 хүнээр цөөрч, нийт цалингийн сан 721.6 сая, 2021 онд 30.9 сая, Орхон АЗЗА ТӨХК-ийн нийт цалингийн сан 2020 онд 46.7 сая, 2021 онд 13.3 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлын хувьд ЭДЦС ТӨХК-ийнх 2021 онд 194.2 сая, 2021 онд 1,517.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн, Орхон АЗЗА ТӨХК-ийнх 2020 онд 2.7 сая төгрөгөөр буурч, 2021 онд 17.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

**Б.2 Төрийн өмчит хуулийн этгээдийн орлого зорилтот түвшнийг хангасан боловч Орхон АЗЗА ТӨХК татварын хуримтлагдсан өр төлбөртэй байна.**

**2.2.1.Төрийн өмчит хуулийн этгээдийн орлого 2019-2021 онд бүрэн биелсэн байна.**

Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагааны орлого 3 жилийн дунджаар 105.2 хувийн, бусад орлого 89.1 хувийн, нийт орлого компаниудын дунджаар 102.6 хувийн биелэлттэй орлогын төлөвлөгөөг бүрэн хангаж ажилласан байна.

Орлогын гүйцэтгэл.

Хүснэгт №2

сая.төгрөг

Он	Үзүүлэлт	ЭДЦС			Орхон АЗЗА		
		Үндсэн	Бусад	Нийт	Үндсэн	Бусад	Нийт
2019	Төлөвлөгөө	36,632.2	1,479.6	38,111.8	799.0	186.5	985.5
	Гүйцэтгэл	39,760.1	963.0	40,723.1	767.1	313.8	1,080.9
	Дүн	3,127.9	-516.6	2,611.3	-31.9	127.3	95.4
	<b>Биелэлт хувиар</b>	<b>108.5</b>	<b>65.1</b>	<b>106.9</b>	<b>96.0</b>	<b>168.3</b>	<b>109.7</b>
2020	Төлөвлөгөө	41,097.4	1,467.5	42,564.9	782.4	375.3	1,157.7
	Гүйцэтгэл	41,134.2	1,603.4	42,737.6	1,098.8	116.6	1,215.4
	Дүн	36.8	135.9	172.7	316.4	-258.7	57.7
	<b>Биелэлт хувиар</b>	<b>100.1</b>	<b>109.3</b>	<b>100.4</b>	<b>140.4</b>	<b>31.1</b>	<b>105.0</b>
2021	Төлөвлөгөө	45,215.1	1,467.5	46,682.6	1,121.0	216.5	1,337.5
	Гүйцэтгэл	48,429.6	1,599.3	50,028.9	978.1	222.2	1,200.3
	Дүн	3,214.5	131.8	3,346.3	-142.9	5.7	-137.2
	<b>Биелэлт хувиар</b>	<b>107.1</b>	<b>109.0</b>	<b>107.2</b>	<b>87.3</b>	<b>102.6</b>	<b>89.7</b>
Нийт	Төлөвлөгөө	122,944.7	4,414.6	127,359.3	2,702.4	778.2	3,480.7
	Гүйцэтгэл	129,323.9	4,165.7	133,489.6	2,844.0	652.6	3,496.5
	Дүн	6,379.2	-248.9	6,130.3	141.5	-125.7	15.9
	<b>Биелэлт хувиар</b>	<b>105.2</b>	<b>94.4</b>	<b>104.8</b>	<b>105.2</b>	<b>83.9</b>	<b>100.5</b>

Нийт дүнгээр төлөвлөсөн орлого бүрэн биелсэн боловч бусад орлогын төлөвлөгөө зарим жилүүдэд тасарсан байна. Тухайлбал Орхон АЗЗА ТӨХК-ийн 2020 оны бусад орлогын гүйцэтгэл 31.1 хувьтай, ЭДЦС ТӨХК-ийн 2019 оных 65.1 хувьтай байна.

Нийт дүнгээр Орхон АЗЗА ТӨХК-ийн 2021 оны орлогын гүйцэтгэл 89.7 хувьтай байна.

## 2.2.2. Төрийн өмчит компаниудын улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөр, хураамжийн төлөлт харилцан адилгүй байна.

Улс, орон нутгийн төсөвт 2019-2021 онд нийт ЭДЦС ТӨХК 10,715.2 сая төгрөг, Орхон АЗЗА ТӨХК 381.2 сая төгрөг, нийт 11,096.4 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Сүүлийн 3 жилийн хугацаанд төлсөн татвар, хураамж

Хүснэгт №3

сая.төгрөг

№	Үзүүлэлт	ЭДЦС				Орхон АЗЗА				Нийт
		2019	2020	2021	Нийт	2019	2020	2021	Нийт	
1	НӨАТ	1,834.7	2,090.0	1,911.5	5,836.2	93.2	157.3	10.8	261.3	6,097.5
2	ААНОАТ	123.5	38.3	0.0	161.8	1.3	1.5	3.5	6.4	168.2
3	ХХОАТ	910.9	997.0	1,001.5	2,909.4	58.4	23.7	15.7	97.9	3,007.3
4	АТБӨЯХАТ	1.6	1.5	1.2	4.2	0.7	1.7	1.2	3.6	7.8
5	ҮХЭХАТ	204.0	228.6	228.6	661.3	0.0	2.5	1.3	3.8	665.1
6	Газрын төлбөр	153.1	154.1	154.1	461.2	0.0	2.0	2.0	4.1	465.3
7	Усны төлбөр	140.0	136.5	144.8	421.4	0.0	0.0	0.0	0.0	421.4
8	Агаарын бохирдол		27.3	15.1	42.4	0.1	0.3	0.2	0.6	43.0
9	Ноогдол ашиг	51.6	84.2	81.5	217.3		0.5	3.2	3.6	220.9
	<b>Нийт дүн</b>	<b>3,419.4</b>	<b>3,757.5</b>	<b>3,538.4</b>	<b>10,715.2</b>	<b>153.7</b>	<b>189.5</b>	<b>38.0</b>	<b>381.2</b>	<b>11,096.4</b>

ЭДЦС ТӨХК нь төлбөл зохих татвар, хураамжаа хууль, тогтоомжийн хүрээнд бүрэн барагдуулан ажиллажээ.

Орхон АЗЗА ТӨХК нь олон жил дамнасан татварын хуримтлагдсан өр төлбөрийг 2020 онд тодорхой хэмжээгээр барагдуулсан ч 2021 оны эцэст 171.4 сая төгрөгийн татварын өр төлбөртэй байна. 2020 онд тус компанид хийсэн татварын шалгалтаар 5.0 сая төгрөгийн торгууль, 2.8 сая төгрөгийн алданги нийт 7.8 сая төгрөгийн торгууль, алданги төлсөн байна.

Хуримтлагдсан татварын өр төлбөрөөс шалтгаалан Орхон АЗЗА ТӨХК нь орон нутгаас зарласан замын ажлын тендерт оролцох боломжгүй болж, тендерт шалгарсан хувийн аж ахуйн нэгжүүдэд туслан гүйцэтгэгчээр гэрээ байгуулан ажил гүйцэтгэж байна.

Татварын хуримтлагдсан өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэснээр орон нутгийн замын ажлын сонгон шалгаруулалтад өрсөлдөхүйц үнээр оролцож өөрийн орлого, ашгаа нэмэгдүүлэх боломжтой байна.

**Б.3 Санхүүгийн үйл ажиллагаанд Орхон АЗЗА ТӨХК нь үр ашгийн тооцоо хийж, үр нөлөөг дүгнээгүй, санхүүгийн харьцаа үзүүлэлтийг бүрэн хангаагүй хэдий ч түүвэрт хамрагдсан байгууллагууд аудитын хамрах хүрээний хугацаанд эдийн засгийн зорилтот түвшнийг хангаж, нийт 1,476.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.**


### 2.3.1. Эрчим хүчний системийн байгууллага санхүүгийн үйл ажиллагаандаа үр ашгийн тооцоог хийж байна.

Түүвэрт хамрагдсан ТӨХК-иуд нь санхүүгийн үйл ажиллагааны шинжилгээг харилцан адилгүй хийж байна.

ЭДЦС ТӨХК-ийн хувьд санхүүгийн тайлангийн шинжилгээг санхүүгийн тайлан, данс бүрээр, өнгөрсөн оны мөн үе, төлөвлөгөөтэй харьцуулан, хэмнэлт хэтрэлтийн шалтгааныг тодруулан дэлгэрэнгүй тайлбар дүгнэлтийг хийж байна.

Орхон АЗЗА ТӨХК-ийн хувьд аудитын хамрах хугацаанд санхүүгийн тайланд шинжилгээ, үр ашгийн тооцоо хийгээгүй, баримт материал дутмаг, холбогдох мэдээллүүд зөрүүтэй, ажлын хариуцлага алдагдсан байна.

Эдгээр компаниудад сүүлийн 5 жилийн тайланд үндэслэн хийсэн санхүүгийн эрсдэлийн түвшнийг графикаар харуулбал:



(Эрсдэлийн шинжилгээний дэлгэрэнгүй хавсралт №3-аас)

ЭДЦС ТӨХК нь ногоон бүсэд дөхсөн 2 орчимд буюу хүлээн зөвшөөрөх түвшинд байгаа бол Орхон АЗЗА ТӨХК-ийн санхүүгийн эрсдэлийн түвшин хүлээн зөвшөөрөх түвшнээс дээгүүр шар бүсэд 2.01-4.0 хооронд буюу санхүүгийн эрсдэлтэй харагдаж байна.

Үйл ажиллагааны харьцаа үзүүлэлтүүдээс үндсэн хөрөнгийн эргэц өндөр түвшинд анхаарал хандуулах шаардлагатай бусад үзүүлэлт бага түвшинд байна.

Орхон АЗЗА ТӨХК-ийн авлага, өглөгийн эргэцийн үзүүлэлт өндөр болон дунд түвшнээс бууран сүүлийн жилүүдэд бага түвшинд орж ирсэн байна. Энэ нь орлого бага зэрэг нэмэгдэж, авлага, өр төлбөр тодорхой хэмжээгээр буурч байгаатай холбоотой байна.

Хөрөнгө орлого багатай жижиг компанийн хувьд багагүй хувь эзлэх урт хугацаанд төлөгдөөгүй, эргэн төлөгдөх нь тодорхойгүй, хууль хяналтын байгууллагад шилжсэн 2017 онд үүссэн гэрээт ажлын хөлс /Harbin electric international ХХК/ 160.0 сая төгрөгийн авлага, хуримтлагдсан татварын өр төлбөрийг зохих түвшинд шийдвэрлэх нь зүйтэй байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл жил бүр буурч байгаатай холбоотойгоор хөрвөх чадварын харьцааны хувьд бэлэн мөнгөний харьцаа үзүүлэлт өндөр түвшинд байна. Цар тахал, хил гаалийн нөхцөл байдлаас хамаарсан үнийн өсөлттэй уялдуулан салбарын жишиг норм, үнэ тарифыг шинэчлэх шаардлага тулгарч байна.

Түүвэрт хамрагдсан төрийн өмчит компаниудын капиталын бүтцэд хүүтэй зээлийн санхүүжилт байхгүй тул төлбөрийн чадварын үзүүлэлт хангагдаж байна. Харин Орхон АЗЗА ТӨХК-д хэзээ, хэрхэн хариуцан шийдвэрлэх нь тодорхойгүй, үүргийн гүйцэтгэлийг шаардаагүй, хүүгийн төлбөргүй, арав гаруй жилийн өмнө Кувейтийн сангаас ирүүлсэн тоног төхөөрөмжийн хүрээнд үүссэн тус байгууллагын нийт эх үүсвэрийн 60 орчим хувийг эзлэх 626.9 сая төгрөгийн он дамжсан урт хугацаат өр төлбөр бүртгэлтэй байгаа нь өр төлбөрийн харьцаа үзүүлэлтийг өндөр түвшинд хүргэж байна.

Санхүүгийн эрсдэлийг түвшин голчлон ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлтээс хамаарч байна. ЭДЦС ТӨХК болон Орхон АЗЗА ТӨХК нь 2019-2021 онд ашигтай ажилласан

хэдий ч, борлуулалтын орлогын өгөөж, хөрөнгө оруулалтын өгөөж дундаас өндөр эрсдэлтэй түвшинд оршин байна.

ЭДЦС ТӨХК 2019 онд 841.6 сая, 2020 онд 543.5 сая, 2021 онд 54.1 сая төгрөг, Орхон АЗЗА ТӨХК 2019 онд 3.1 сая, 2020 онд 31.7 сая, 2022 онд 2.1 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллажээ. ЭДЦС ТӨХК-ийн цэвэр ашиг жилээс жилд буурч, 2021 онд хүлээн авсан 35 МВт-н өргөтгөлтэй холбоотойгоор 2022 онд 12,676.8 сая төгрөгийн алдагдалтай төсөв батлагдсан байна.


**2.3.2. Санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийн тооцоо, шинжилгээний үр нөлөөг ЭДЦС ТӨХК нь тооцож шийдвэр гаргаж байхад Орхон АЗЗА ТӨХК нь санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийн тооцоо хийдэггүй тул үр нөлөөг тооцох боломжгүй, санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд бүрэн хангагдахгүй байна.**

ЭДЦС ТӨХК нь Сангийн сайдын тушаалаар баталсан санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн журмын хүрээнд санхүүгийн харьцаа, үр ашгийн шинжилгээг хийж, холбогдох эрх бүхий этгээдэд танилцуулан, үйлдвэрлэлийн болон санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг шийдвэр гаргалтдаа ашиглаж байна.

ЭДЦС ТӨХК, Орхон АЗЗА ТӨХК-ийн сүүлийн 5 жилийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн нөхцөл байдлын шинжилгээ.

1. Төлбөрийн чадварын шинжилгээ.

График №6



(ТХХХ - Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа, ЭХ – Эргэлтийн харьцаа)

Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа 0.8-1, Эргэлтийн харьцаа 1.5-аас дээш байх нь оновчтой гэж үздэг бөгөөд дээрх 5 жилийн дундаж үзүүлэлтээр ЭДЦС ТӨХК-ийн ТХХХ-12.9, ЭХ-26.1, Орхон АЗЗА ТӨХК-ийн ТХХХ-1.6, ЭХ-2.2 байгаа нь шалгуурыг бүрэн хангаж байна.

## 2. Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ<sup>4</sup>.

График №7



График №8



(Санхүүгийн тайлангийн шинжилгээний дэлгэрэнгүйг хавсралт 4-оос)

ЭДЦС ТӨХК-ийн бие даах чадварын дундаж 0.94, санхүүгийн хамаарлын коэффициентынх 1.06-тай байгаа нь хангалттай үзүүлэлт байна. Орхон АЗЗА ТӨХК-ийн бие даах чадварын коэффициентын дундаж 0.23, санхүүгийн хамаарлын коэффициент 4.33 гарч тус компанийн санхүүгийн тогтвортой байдал муу байгааг илтгэж байна.

5 индексийн нийлбэрээр үнэлж дампуурах магадлалыг тооцоход ашигладаг альтманы индекс - (Z)<sup>5</sup> дунджаар ЭДЦС ТӨХК-158.6, Орхон АЗЗА ТӨХК-1.9 гарч байна. Альтманы индексийн үзүүлэлтийн утгаас харахад Орхон АЗЗА ТӨХК нь дампуурах магадлалтай, ЭДЦС ТӨХК нь дампуурах магадлалаас хол байна.

Орхон АЗЗА ТӨХК-д олон жилийн насжилттай өр төлбөр, авлага бүрэн барагдах боломжгүй байгаагаас шалтгаалж орон нутгаас зарлагдаж буй замын тендер сонгон шалгаруулалт оролцож орлогоо нэмэгдүүлэх боломжийг хаагдуулсан нь тус компанийг ганц Зам тээврийн яамнаас хамааралтай болгоход нөлөөлсөн. Мөн үндсэн техник тоног төхөөрөмжүүд хуучирсан, замын ажлын үндсэн орц болох асфальт бетон хольцын үйлдвэргүйгээс шалтгаалж Орхон аймагт монопол 2 асфальт бетон хольцын үйлдвэрээс шууд худалдан авалт хийдэг зэрэг нь олон жилийн турш үйл ажиллагаа явуулахдаа компанийн материаллаг баазыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг ашигтай ажиллахад гол анхаарал хандуулаагүйг илэрхийлж байна.

ЭДЦС-ын хувьд байгууллагын үр ашигт байдлыг хангахын тулд санхүүгийн үр ашгийн тооцоо судалгааг хийж, үнэлдэг байхад Орхон АЗЗА ТӨХК-ийн хувьд санхүүгийн үр ашгийн тооцоо судалгаа огт хийж, үнэлж дүгнэдэггүйгээс байгууллагын үйл ажиллагааны ашигт ажиллагаа буурсаар байна. Иймд Орхон АЗЗА ТӨХК нь жил бүрийн санхүүгийн тооцоонд тулгуурлан үр ашгийн тооцоо судалгааг хийж, үнэлж дүгнэж байгууллагын үр ашгийг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

<sup>4</sup> Аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээ, бүтэц бүрэлдэхүүн, түүний өөрчлөлт зэрэг нь санхүүгийн тогтвортой байдлыг харуулах үндсэн үзүүлэлт болдог. Бие даах чадварын коэффициент 0.5-аас их байвал хангалттай гэж үздэг бөгөөд санхүүгийн тогтвортой байдлын коэффициент нь эсрэг үзүүлэлт болно.

<sup>5</sup>  $Z < 2.675$  – ойрын 2.-3 жилдээ дампуурах магадлалтай,  $Z > 2.675$  – жилдээ дампуурах магадлалгүй.

**Б.4. Үйл ажиллагааны зардлыг батлагдсан зорилтот түвшний хүрээнд хэмнэлттэй зарцуулсан боловч зарим үр ашиггүй зардал гаргасан байна.**

**2.4.1. Удирдлагын зардлыг батлагдсан зорилтот түвшнээс хэмнэлттэй зарцуулсан байна.**

ЭДЦС ТӨХК нь жил бүр удирдлагын зардал нийт дүнгээр хэмнэлттэй зарцуулагдаж буй боловч 2019 онд Захиргааны зардал, ТУЗ-ийн зардал тус тус хэтэрсэн байна. Энэ нь тус онд ТУЗ болон байгууллагын ажилчдын цалинг нэмсэнтэй холбоотой байна.

ЭДЦС ТӨХК-ийн удирдлагын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №4

сая.төгрөг

№	Зардлын төрөл	2019 он		Зөрүү	2020 он		Зөрүү	2021 он		Зөрүү
		Төлөв	Гүйц		Төлөв	Гүйц		Төлөв	Гүйц	
1	Захиргааны зардал	340.6	347.2	-6.6	379.2	359.5	19.7	419.9	360.2	59.8
2	ТУЗ-ын зардал	61.0	68.5	-7.5	92.3	91.2	1.1	101.7	89.7	11.9
3	Ерөнхий зардал	697.3	682.8	14.6	750.5	715.8	34.7	836.9	705.4	131.5
<b>НИЙТ ДҮН</b>		<b>1,099.0</b>	<b>1,098.5</b>	<b>0.5</b>	<b>1,221.9</b>	<b>1,166.4</b>	<b>55.5</b>	<b>1,358.5</b>	<b>1,155.3</b>	<b>203.2</b>

Харин 2021 онд аж ахуй эрхэлсэн дэд захирал, гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн 1 гишүүний сонгон шалгаруулалтын хугацааны цалин, НДШ-ийн зардлын хэмнэлт, шатахууны зардал, ерөнхий зардлын хэмнэлт нийт 203.2 сая төгрөгийн зардал хэмнэжээ.

2021 онд өргөтгөлийн ажилтай холбоотойгоор 204.0 сая төгрөгийн төсөв батлагдсан ч нээлтийн үйл ажиллагааны болон баримтат кино хийх зардал зэрэг нийт 155.3 сая төгрөг хэмнэсэн байна.

ЭДЦС ТӨХК-ийн нийт албан хаагчид нь үйлдвэрлэлийн болон санхүүгийн сарын болон жилийн ажлын үзүүлэлтээр холбогдох журмын хүрээнд үр дүнгийн шагналт цалин, урамшуулал авдаг байна. Энэхүү сарын болон жилийн үр дүнгийн шагналт цалин, ажилласан хугацааны нэмэгдлийг гүйцэтгэх захирал нь эрх бүхий этгээдийн шийдвэр гаргуулалгүйгээр нийт ажилчдын нэгэн адил холбогдох журмын хүрээнд өөртөө тооцон авч байна.

Орхон АЗЗА ТӨХК-ийн хувьд 2020 төлөвлөсөн удирдлагын зардал хэмнэгдсэн боловч татварын хэлтсээс 5 жилийн үйл ажиллагаанд орсон төлөвлөгөөт шалгалтаар нөхөн төлбөрийн акт, торгууль, алданги төлсөнтэй холбоотойгоор зардал хэтэрсэн байна. Харин 2020, 2021 онд гүйцэтгэлээр зардал хэмнэгдэж гарсан байна.

Орхон АЗЗА ТӨХК-ийн удирдлагын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №5

сая.төгрөг

№	Зардлын төрөл	2019 он		Зөрүү	2020 он		Зөрүү	2021 он		Зөрүү
		Төлөв	Гүйц		Төлөв	Гүйц		Төлөв	Гүйц	
1	Захиргаа удирдлагын зардал	168.1	142.3	25.8	186.2	215.8	-29.6	202.4	198.5	3.9
2	ТУЗ-ын зардал	20.7	19.2	1.5	33.2	26.1	7.1	32.9	27.2	5.7
<b>НИЙТ ДҮН</b>		<b>188.8</b>	<b>161.5</b>	<b>27.3</b>	<b>219.4</b>	<b>241.9</b>	<b>-22.5</b>	<b>235.3</b>	<b>225.7</b>	<b>9.6</b>

Орхон АЗЗА ТӨХК-ийн гүйцэтгэх захирал өөртөө холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр 2021 оны 6,7,10-р сард нийт 1.1 сая төгрөгийн илүү цагийн хөлс бодож олгосон тул аудитын явцад төлбөрийн акт тогтоосон.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд гүйцэтгэх захирлын нэмэгдэл цалин хөлс, урамшуулал тооцож олгох нь хориглосон зохицуулалттай болно.

#### 2.4.2. Батлагдсан орон тооны хүрээнд үйл ажиллагаа явуулсан боловч зарим үр ашиггүй зардлыг гаргасан байна.

ЭДЦС ТӨХК-ийн үйл ажиллагааны зардлыг нэгж, хэлтэс, цех бүрээр зардлуудыг төлөвлөн компанийн хэмжээнд үе шаттай хянан нэгтгэж, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн ЭХЯ, ТӨБЗГ, ЭХЗХ-ны ажлын хэсэг хянан Эрчим хүчний сайд баталдаг байна.

ЭДЦС ТӨХК нь цалин урамшууллыг батлагдсан орон тоонд нийцүүлэн дүрэм журмын хүрээнд тооцон олгосон байна.

Орон тоо, цалингийн төлөвлөгөө гүйцэтгэл

Хүснэгт №6

сая.төгрөг

№	Үзүүлэлт	2019 он		Зөрүү	2020 он		Зөрүү	2021 он		Зөрүү
		Төлөв	Гүйц		Төлөв	Гүйц		Төлөв	Гүйц	
1	Ажиллагсдын тоо	459	454	5	450	449	1	450	449	1
2	Цалингийн сан	9,892.8	9,536.0	356.8	10,531.4	10,508.6	22.8	10,716.7	10,692.9	23.8
3	Жилийн үр дүн	1,005.4	1,029.5	-24.1	1,088.4	1,099.6	-11.2	934.0	924.8	9.3
<b>Дүн</b>		<b>10,898.2</b>	<b>10,565.5</b>	<b>332.7</b>	<b>11,619.8</b>	<b>11,608.2</b>	<b>11.6</b>	<b>11,650.7</b>	<b>11,617.7</b>	<b>33.0</b>

Цалингийн зардлыг жил бүр хэмнэлттэй зарцуулсан байна. Энэ нь орон тооны хэмнэлттэй холбоотой. Тухайлбал: 2019 онд жилийн ажлын үр дүнгийн цалинг 3 сараар олгохоор төлөвлөснөөс дунджаар 3.2 сараар олгож 24.1 сая төгрөг хэтрүүлсэн хэдий ч өргөтгөлийн ажилтай холбоотойгоор 22 хүнээр орон тоо нэмэгдсэнээс 5 хүнийг аваагүй, 17 хүнийг жилийн турш бус дунджаар 6 сар орчим ажиллуулсан, сарын ажлын үр дүнгийн шагналт цалин, цалингийн гүйцэтгэлтэй холбоотой /ажлаас халагдсан, арга хэмжээ авагдсан болон өндөр насны тэтгэвэрт гарсан ажилчдын удаан жилийн нэмэгдэл, цаг зэрэг тарифт цалингийн зөрүү/ жилийн дүнгээр нийт 332.7 сая төгрөг хэмнэсэн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшин гүйцэтгэлээр жил бүр давж биелж үндсэн үйлдвэрлэлийн зардал нэмэгдсэн ч нийт зардал гүйцэтгэлээр жил бүр хэмнэлттэй гарсан байна. Тухайлбал 2019 онд гүйцэтгэлээр 39,777.3 сая төгрөг зарцуулж 733.6 сая төгрөг, 2020 онд 42,144.2 сая төгрөг зарцуулж 420.7 сая төгрөг, 2021 онд 49,968.4 сая төгрөг зарцуулж 2,838.3 сая төгрөг тус тус хэмнэсэн байна.

Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардлыг 2019 онд 1.06 төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 0.98 төгрөг, 2020 онд 1.0 төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 0.99 төгрөг, 2021 онд 1.13 төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 1.0 төгрөгийн зардал тус тус тооцсон байна./ЭДЦС ТӨХК-ийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн 2019-2021 оны биелэлтийг хавсратл №5-аас дэлгэрэнгүй үзнэ үү./

ЭДЦС ТӨХК нь үйлдвэрчний эвлэлийн хороотойгоо жил бүр хамтын гэрээгээ шинэчлэн байгуулж ажилласан байна. Хамтын гэрээний заалтаар дараах үр ашиггүй зардлуудыг гаргасан байна. Үүнд:

- Гүйцэтгэх захирлын 2019.03.19-ны өдрийн Б/64 дугаар тушаалаар хамтын гэрээний 4.7<sup>6</sup> дахь заалтыг үндэслэн тухайн үеийн Эрчим хүчний сайдыг компанийн “Хүндэт дэвтэр”-т нэрийг нь бичиж, 1 сарын үндсэн цалин<sup>7</sup> гэж 3.3 сая төгрөгөөр,
- Гүйцэтгэх захирлын 2019.05.01-ны өдрийн Б/92 дугаар тушаалаар хамтын гэрээний 4.32<sup>8</sup> дахь заалтыг үндэслэн (2019.06.21-ний өдөр баталсан хамтын гэрээний 4.32 дахь заалт) “Хэрэглэгчдийн зөвлөгөөн”-ийг тохиолдуулан нийт 21 иргэн, 3 аж ахуй нэгжийг 2.5 сая төгрөгөөр
- Гүйцэтгэх захирлын 2020.03.09-ны өдрийн Б/76 дугаар тушаалаар хамтын гэрээний 4.32 дахь заалтыг үндэслэн Эрчим хүчний зохицуулах хороог 3.9 сая төгрөгөөр (хамтын гэрээгээр тодорхойлсон хэмжээнээс илүү олгосон 1.9 сая төгрөгт төлбөрийн акт тогтоосон),
- Гүйцэтгэх захирлын 2020.12.30-ны өдрийн Б/334 дугаар тушаалаар хамтын гэрээний 4.32 дахь заалтыг үндэслэн Баян-Өндөр сумын ЗДТГ-ын дарга, программ хангамжийн инженер, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн нарыг нийт 0.5 сая төгрөгөөр,
- Гүйцэтгэх захирлын 2021.12.10-ны өдрийн Б/319 дүгээр тушаалаар хамтын гэрээний 9.19<sup>9</sup> дэх заалтыг үндэслэн Монголын хувьсгалт залуучуудын эвлэлийн ахмад ажилтнуудын холбоог 0.5 сая төгрөгөөр тус тус шагнаж урамшуулжээ.

Хөдөлмөрийн тухай хуулийн 3.1.4-т<sup>10</sup> зааснаар (2022.01.01-ны өдрөөс мөрдөх Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 4.1.7 дахь заалт) хамтын гэрээ нь дотоодод чиглэсэн нийт ажилтны хөдөлмөрлөх эрхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг байтал тус байгууллагын хамтын гэрээнд гадагш буюу өөр байгууллага, хүнд чиглэсэн зохицуулалттай заалт тусгагджээ.

Мөн гүйцэтгэх захирлын 2020.12.03-ны өдрийн Б/313 дугаар тушаалаар Ковид-19 цар тахалтай холбогдуулан 50 тн нүүрс нийгмийн хариуцлагын хүрээнд түлээ, түлшээ бэлдээгүй, амьдралын боломж тааруу хүмүүст туслах зорилгоор Орхон аймгийн онцгой комисст гэж

<sup>6</sup> Хамтын гэрээний 4.7: "Компанийн “Хөдөлмөрийн аварга”-ыг 2'000'000 төгрөг, үндсэн цехийн “Ажил мэргэжлийн аварга”-ыг 1'500'000 төгрөг, бусад “Ажил мэргэжлийн аварга”-ыг 1'200'000 төгрөг, “Тэргүүний инженер техникийн ажилтан”-ыг 1'200'000 төгрөг, “Шилдэг ШБАЗ-ын аварга”-ыг 1'200'000 төгрөг, Компанийн “Хүндэт дэвтэр”-т нэр нь бичигдсэн ажилтанг 1 сарын үндсэн цалингаар, МШӨ группд буй хүмүүсийг салбарын хөдөлмөрийн доод хэмжээтэй дүйх мөнгөн шагналаар тус тус шагнана.

<sup>7</sup> Тухайн үеийн сайдын үндсэн цалин нь 1.7 сая төгрөг байхаар байна. УИХ-ын 2019 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан албан тушаалын зэрэглэл, 2019 оны 63 дугаар /2011 оны 36/ тогтоолоор батлагдсан цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийн дагуу тооцсон. Тухайн үеийн яамны ТНБД-н хамгийн өндөр шатлалын /ТЗ-14/ цалин  $1.1 \text{ сая} * 1.49 = 1.7 \text{ сая төгрөг}$

<sup>8</sup> Хамтын гэрээний 4.32-д "Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулсан, ажил төрлийн холбоотой аж ахуйн нэгж байгууллагуудыг 2'000'000 хүртэл төгрөг, холбогдох ажилтнуудыг 200'000 хүртэл төгрөгөөр шагнаж урамшуулж болно"

<sup>9</sup> Хамтын гэрээний (2020.12.25-ны өдрийн) 9.19 дэх заалт нь 2019.06.21-ны өдрийн хамтын гэрээний 4.32 дахь заалт

<sup>10</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн 3.1.4-т "хамтын гэрээ" гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажилтны хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах болон энэ хуулиар шууд зохицуулаагүй асуудлаар ажил олгогч, ажилтны төлөөлөгчдийн хооронд байгуулсан тохиролцоог

иргэдэд тараасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль<sup>11</sup>, Төсвийн тухай хуулийн<sup>12</sup> төрийн өмчит компанийн хандив өгөхийг хориглосон заалттай нийцэхгүй байна.

ЭДЦС ТӨХК нь ажилтнуудыг орон сууцжуулах, хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журмыг ТУЗ-өөр батлуулан энэ хүрээнд жилийн төсөвтөө 200.0 сая төгрөг тусгаж шаардлага хангасан албан хаагчдыг журамд заасан хэмжээгээр орон сууцны хөнгөлөлт олгодог байна.

Гүйцэтгэх захирлын 2019 оны Б/168 дугаар тушаалаар 8.0 сая төгрөгийн орон сууцны хөнгөлөлтөд хамрагдсан гэрээний мэргэжилтэн нь ЭДЦС ТӨХК-д 2016 онд ажилд ороод 2021 онд Дулааны гуравдугаар цахилгаан станцад шилжжээ. Уг ажилтныг өөрийнх нь хүсэлтээр ажлаас чөлөөлсөн бөгөөд ТУЗ-ийн 2018 оны 17 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ажилтнуудыг орон сууцжуулах, орон байрны нөхцөлийг сайжруулахад дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 5.4<sup>13</sup> дэх заалтын хүрээнд анх авсан хөнгөлөлтөөс ажилласан жилээс хамаарсан дүнг хасаж, буцаан төлүүлэх боломжтой 5.5 сая төгрөгийг тооцоог нэг системийн байгууллагад шилжин ажилласан шалтгаанаар хийгээгүй байна.

Дээрх журмыг ТУЗ-ийн 2021 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар “Ажилтнуудад орон сууцны хөрөнгийн дэмжлэг үзүүлэх журам” болгон шинэчлэн баталсан бөгөөд гүйцэтгэх захирлын 2021 оны Б/87 дугаар тушаалаар 19 ажилтанд нийт 190.0 сая төгрөгийн дэмжлэг олгохдоо энэхүү журмын 3.1-ийн Г-д заасан “орон сууцны зээлтэй байх” гэсэн үндсэн шаардлагыг хангахгүй нийт 13 хүнийг хамруулсан байна.

Мөн гүйцэтгэх захирлын 2021 оны Б/155 дугаар тушаалаар Ажилтнуудад орон сууцны хөрөнгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 4.7-д “гүйцэтгэх захирлын шийдвэрээр жилд 1 ажилтанд дараалал харгалзахгүй орон сууцны дэмжлэг үзүүлж болно” гэж заасныг үндэслэн тухайн үеийн СЭЗЭ дэд захиралд орон сууцны дэмжлэг 10.0 сая төгрөг олгосон байна.

Гүйцэтгэх захирлын 2020.10.27-ний өдрийн Б/278 дугаар тушаалаар компанийн төрсөн өдрийг анх удаа тэмдэглэж буйг тохиолдуулан бүх ажилтанд тус бүр 0.2 сая буюу нийт 89.2 сая төгрөг, гүйцэтгэх захирлын 2021.09.07-ний өдрийн Б/209 дугаар тушаалаар станцын өргөтгөлийн ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн гэж бүх ажилтанд тус бүр 0.2 сая буюу нийт 90.2 сая төгрөг цалингийн зардлаас тус тус олгож үр ашиггүй зардал гаргасан байна.

ЭДЦС ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дээрх 90.2 сая төгрөгийн зөрчилд дахин давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлсэн байна.

Захирлын зөвлөлийн 2020.10.21-ны өдрийн хурлаар тухайн үеийн гүйцэтгэх захирлыг байгууллагынхаа “Хүндэт дэвтэр”-т нэрийг нь бичихээр дэмжиж, эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр үйлдвэрлэл эрхэлсэн тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер нь хамтын гэрээний 4.7 дахь заалтын дагуу 2020.10.27-ны өдөр Б/281 дугаар шагнах тухай тушаал гаргаж 1 сарын үндсэн цалин буюу 3.8 сая төгрөг олгожээ. Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар тэргүүн дэд захирал нь компанийн хөрөнгийг захиран зарцуулах эрхгүй бөгөөд компанийн тухай хуулийн 84.4.1<sup>14</sup> дэх заалттай нийцэхгүй байна.

<sup>11</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 3-д “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно”

<sup>12</sup> Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-д “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно”


<sup>13</sup> Журмын 5.4 дэх заалт. Хөнгөлөлт, дэмжлэгт хамрагдсан ажилтан өөрийн хүсэлтээр болон Захиргааны санаачилгаар ажлаас халагдсан тохиолдолд нийт ажилласан жилийг 0.5 сая төгрөгөөр тооцоолон хасуулж, авсан хөнгөлөлт, дэмжлэгийн үлдэгдэл мөнгийг буцааж төлнө. Өндөр насны тэтгэвэр, мэргэжлээс шалтгаалах болон бусад өвчнөөр чөлөөлөгдөх, сонгуульт ажил, албан тушаалд томилогдох, томиллоор өөр байгууллагад шилжсэн ажилтанд энэ заалт хамаарахгүй.

<sup>14</sup> Компанийн тухай хуулийн 84.4. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй. 84.4.1-д “хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх”

Орхон АЗЗА ТӨХК нь цалингийн зардлыг ТУЗ-аас баталсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан тогтоосон цалин хөлсийг олгосон байна.

Орхон АЗЗА ТӨХК-ийн батлагдсан орон тоо, цалингийн зардлын гүйцэтгэл.

График №9



Цалингийн зардал 2020 онд хэтэрсэн нь давсан орлогын гүйцэтгэлтэй уялдан зардал нэмэгдсэн байна. Харин 2019 болон 2021 онд орон тоо дутуу ажилласан тул цалингийн зардал хэмнэлттэй гарчээ.

Орхон АЗЗА ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх ерөнхий нягтлан бодогч өөртөө цалин илүү тооцож авсан болон хүмүүсийн цалингийн суутгалыг дутуу хийсэнтэй холбоотой зөрчлүүдийг илрүүлж төлбөрийн акт тогтоосон байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшний биелэлтээр Орхон АЗЗА ТӨХК нь 2019, 2020 онд нийт орлого давж биелсэн бөгөөд орлого олохтой холбоотойгоор нийт зардал хэтэрсэн байна. Тухайлбал 2019 онд нийт 1,058.2 сая төгрөг зарцуулж, 95.4 сая төгрөгөөр, 2020 онд 1,134.6 сая төгрөг зарцуулж, 45.6 сая төгрөгөөр нийт зардлыг хэтрүүлэн зарцуулсан бол 2021 онд нийт 1,198.0 мянган төгрөгийн зардал гаргаж 86.4 мянган төгрөг хэмнэсэн байна. /Орхон АЗЗА ТӨХК-ийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн 2019-2021 оны биелэлтийг хавсратл №5-аас дэлгэрэнгүй үзнэ үү/

#### **2.4.3. Үйл ажиллагааны явцад үүссэн төлөвлөөгүй худалдан авалт нь гэнэтийн нөхцөл байдлаас шалтгаалан зайлшгүй шаардлагаар үүсэх бөгөөд холбогдох журам зааврын хүрээнд шийдвэрлэж байна.**

Тухайн оны их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг стратеги төлөвлөгөөний дагуу, их засваруудын графикт хугацаа, гэмтлийн судалгаа, эрсдэлийг тооцож, урьдчилан гарах үр дүн зэргийг тооцож төлөвлөн ТУЗ-д танилцуулан ЭХЯ-аар батлуулан ажиллаж байна.

Зайлшгүй гэмтэл, саатал, байгалийн давагдашгүй хүчин зүйл, тоноглолын насжилт, дээд байгууллагуудын хэмжилт, шалгалтын үр дүн зэрэг олон хүчин зүйлсээс төлөвлөгдөөгүй хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага гарч байна. Энэ үед гэмтлийн мэдээ, гэмтлийн актыг үндэслэн, материалын захиалга өгч удирдлагад танилцуулан томоохон хэмжээний хамрах хүрээ өргөнтэй ажлуудыг комиссын гишүүд хуралдан, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийх зэргээр шийдвэрлэж байна.

Орхон АЗЗА ТӨХК-ийн хувьд насжилт өндөртэй тээврийн хэрэгслүүдэд төлөвлөснөөс гадна гэнэтийн эвдрэл гэмтлээс үүссэн зардлыг байгууллагын сэлбэг хэрэгслийн төсөвт багтаан шийдвэрлэж байна.

### **БҮЛЭГ 3. ХЯНАЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

**В.1. Хөндлөнгийн хяналтаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлын хүрээнд холбогдох арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлсэн байна.**

**3.1.1.Төрийн байгууллагуудаас төрийн өмчит газруудад холбогдох чиглэл, журам, удирдамжийн хүрээнд хяналт шалгалт тогтмол хийгдэж байна.**

ЭДЦС-ТӨХК-ийн хувьцаа эзэмшлийг хэрэгжүүлж буй төрийн төлөөлөл болох ЭХЯ-сайдын тушаалаар баталсан “Эрчим хүчний салбарын аж ахуйн нэгж байгууллагад дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ын дагуу төлөвлөгөө хөтөлбөр боловсруулан үзлэг шалгалтыг хийдэг байна. Тус үзлэг шалгалтаар өвөлжилтийн бэлтгэл ажил, техник тоног төхөөрөмжийн ашиглалт, технологийн найдвартай ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, хөрөнгө оруулалтын үр ашиг зэрэгт үнэлэлт өгөх, өмнөх онуудын хяналт шалгалтын биелэлтийг шалгах зэрэг чиглэлүүдээр хийж байна. Дээрх шалгалт нь 2019 онд 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг үндсэн 4 чиглэлд 29 асуудлаар, 2020 онд 14 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 6 чиглэлд хяналт шалгалтуудыг тус тус хийж тухай бүр зөвлөж өгч ажилласан байна

ЭХЯ-аас ЭДЦС ТӨХК-ийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналт шалгалтаар 2019 онд 4 үндсэн асуудлаар, 2020 онд 3 үндсэн асуудлаар зөвлөмжүүдийг авсан бөгөөд зөвлөмжийн дагуу хийх ажлын төлөвлөгөөг гарган биелэлтийг ханган ажилласан байна. Мөн аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан хяналт шалгалтын удирдамжаар 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс дулааны станцын үйл ажиллагаанд 7 чиглэлээр шалгалтыг хийж 49 зөвлөмж хүргүүлсэн.

Орхон АЗЗА ТӨХК-ийн хувьд мөн холбогдох төрийн байгууллага болон зам арчлалтын хяналтууд тухай бүр хийгдэж байна. Биет хяналт, шалгалтууд Ковид 19 цар тахлын нөлөөллөөр 2021 онд хийгдээгүй байна.

**3.1.2.Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг санхүүгийн тайлангийн аудитаар голчлон хэрэгжүүлж, аудитаар илэрсэн зөрчил, дутагдлын хүрээнд холбогдох хариуцлагын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн цаглаврын хүрээнд санхүүгийн тайлангийн аудит хийгдэж байна.

ЭДЦС ТӨХК-ийн 2019, 2020 оны санхүүгийн тайлангийн аудитыг "Б энд С аудит" ХХК, "Ниямазон аудит" ХХК, 2021 он болон Орхон АЗЗА ТӨХК-ийн 2019-2021 оны санхүүгийн тайлангийн аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газраас гүйцэтгэсэн.

ЭДЦС ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 6.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж, 2020 оны санхүүгийн аудитын тайлангаар 41.9 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж, 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3.0 сая төгрөгийн зөрчилд төлбөр барагдуулах 4 акт, 90.0 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1,902.2 мянган төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж тус тус хүргүүлсэн байна.

Орхон АЗЗА ТӨХК-ийн 2019-2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 30.5 сая төгрөгийн 8 албан шаардлага, 41.0 сая төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж, 14.8 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоожээ.

ЭДЦС ТӨХК-ийн хувьцаа эзэмшлийг хэрэгжүүлж буй төрийн төлөөллийн байгууллагаас санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тухайлбал зөвлөмжөөр өгсөн алдаа зөрчил давтагдаагүй, Орхон АЗЗА ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 14.8 сая төгрөгийн 3 төлбөрийн акт нь компанийн тухай хууль, компанийн дүрмээр тодорхойлсон эрх бүхий албан тушаалтанд хамаарах бөгөөд уг актыг зөрчил гаргасан эрх бүхий албан тушаалтнаар төлүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал болон ТӨБЗГ-аас санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын хүрээнд Орхон АЗЗА ТӨХК-ийн ерөнхий нягтлан бодогчийг 2 удаа, гүйцэтгэх захирлыг 1 удаа ажлаас нь чөлөөлж хариуцлага тооцсон байна.

**В.2 Холбогдох зохицуулалтын хүрээн дэх дотоод хяналтуудад үр дүнгийн үнэлэлт хийгээгүй байна.**

**3.2.1. ТУЗ-ын дэргэдэх дотоод аудитын хороо нь санхүүгийн тайланд үнэлэлт, дүгнэлт гаргаж гүйцэтгэх удирдлагад зөвлөмж хүргүүлж буй боловч хэрэгжилтийг хянаагүй байна.**

ЭДЦС ТӨХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 01 дүгээр сарын 16-ны 6 дугаар тогтоолоор ТУЗ-ын дэргэдэх аудитын хороог байгуулан, хорооны үйл ажиллагааны журам, 2020 оны 03 дугаар сарын 13-ны 9 дүгээр тогтоолоор аудитын хорооны дарга гишүүдийг сонгосон байна. Тус хороо нь компанийн үйл ажиллагаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, авлага, өглөг, санхүүгийн тайлан, тайлангийн харьцаа үзүүлэлтэд хагас бүтэн жилээр дүгнэлт гарган, зөвлөмж өгч ажилласан боловч хэрэгжилтийн талаар авсан арга хэмжээ байгүй байна.

Орхон АЗЗА ТӨХК-ийн ТУЗ, ТУЗ-ын дэргэдэх холбогдох хороодын тайлан, мэдээлэл материалыг аудитын багт ирүүлээгүй бөгөөд ТУЗ-ын нарийн бичгийн дарга нь 2021 онд солигдсон, өмнөх ажилтан нь архивын баримт материалыг зохион бүрдүүлж, хэрхэн хүлээлгэж өгсөн нь мэдэгдэхгүй, баримт материалын хадгалалт, хамгаалалт алдагдсан тул байгууллага дээрээс нь ТУЗ-ийн нарийн бичиг томилох асуудлыг тавьж Орхон АЗЗА ТӨХК-ийн нярвыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар томилсон байна.

Санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн баталгаажуулж гүйцэтгэх удирдлагад холбогдох зөвлөмжийг хүргүүлж буй боловч мөн хэрэгжилтийг дүгнэдэггүй байна.

**3.2.2. Байгууллага дээрх дотоод хяналт шалгалт, эрх бүхий байгууллагын баталсан дүрэм журмын хүрээнд хийгдэж байна.**

ЭБЦС ТӨХК нь дотоод хяналт шалгалт хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 04-р сарын 06-ны өдрийн 11 дүгээр тогтоол, “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 4.1.9 дэх заалтыг үндэслэн гүйцэтгэх захирлын 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/92 тоот тушаалаар дотоод хяналтын хэлтсийг байгуулсан байна.

Эрчим хүчний салбарын “Дотоод хяналт шалгалтыг зохион явуулах журам” 2021 онд шинэчлэгдсэнтэй холбогдуулан дотоод хяналтын бүтэц, зохион байгуулалтыг гүйцэтгэх захирлын 2021.09.07-ны өдрийн №А/80 дүгээр тушаалаар баталж, санхүүгийн хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хяналт, техникийн аюулгүй байдал, хэмжил зүй, байгаль орчны хяналт, хууль эрх зүйн хяналт, галын аюулгүй байдал, гамшиг эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт гэсэн чиглэлээр байнгын, төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хэлбэрээр дотоод хяналтыг хэрэгжүүлж байна. 2019 оны дотоод хяналт шалгалтаар 84 ажил төлөвлөж биелэлт 98 хувьтай, 2020 онд 94 ажил хийхээр төлөвлөж биелэлт 96.8 хувьтай, 2021 онд 93 ажил хийхээр төлөвлөж биелэлт 95.9 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчилтэй асуудлаар, хариуцсан цехийн даргад зөвлөмж өгч биелэлтийг хангуулж байна.

Орхон АЗЗА ТӨХК-ийн хувьд Засгийн газрын 2021 оны 311 дүгээр тогтоолын хүрээнд компанийн дотоод хяналт шалгалтын комиссыг ерөнхий инженерээр ахлуулан байгуулсан байна. Энэхүү комисс нь журмыг хэрэгжүүлэх хүрээнд болохоос биш компанийн дотоод хяналт, эрсдэлийн удирдлага нь эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагаагаар дамжин хэрэгжиж байна.

**В.3 Мэдээллийн ил тод байдлыг шилэн дансны тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлж байна.**

**3.3.1. Холбогдох байгууллагуудад шаардлагатай мэдээллийг тухай бүр хүргүүлж байна.**

Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд санхүүгийн тайлангийн аудит хийлгэж аудитын тайлан, дүгнэлтийг ТӨБЗГ, ЭХЯ, бусад холбогдох байгууллагад хүргүүлдэг, ТУЗ-аар хэлэлцүүлж баталгаажуулж байна.

**3.3.2. Шилэн дансны нэгдсэн цахим систем, байгууллагын вэб сайт, пэйж хуудсаар мэдээлэл хүргэж байна.**

ЭДЦС ТӨХК нь байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ тайланг хэдий хугацаанд ямар байгууллагад хүргүүлэх талаар бодлогын баримт бичигт тусгаж өгсөн байна.

Байгууллагын өөрийн <http://erdpp.energy.mn/> вэб сайтад холбогдох мэдээллийг оруулдаг байна.

Шилэн дансны хууль, түүнийг хэрэгжүүлэх журам зааврын хүрээнд шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан холбогдох мэдээллийг хүргэж байна.

ЭДЦС ТӨХК нь шилэн дансны мэдээллийг хугацаанд нь үнэн зөв оруулдаг бөгөөд дотоод хяналтын хэлтэс хянаж чиглүүлдэг байна

Орхон АЗЗА ТӨХК-ийн хувьд 2019-2020 онд шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээлэл байршуулалт хугацаа хоцролт ихтэй байна. 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хөтлөлттэй холбоотойгоор албан шаардлага хүргүүлсэн байна.

**ДҮГНЭЛТ:** ЗАСАГЛАЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ТОДОРХОЙ БОЛГОХ, АУДИТЫН ХАМРАХ ХУГАЦААНД 1,476.1 САЯ ТӨГРӨГИЙН АШИГТАЙ АЖИЛЛАСАН ХЭДИЙ Ч САНХҮҮГИЙН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАНГАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төрийн өмчийн компанийн засаглалын төрийн бодлого, эрх зүйн зохицуулалт хангалтгүй нь тодорхой бус байдлыг үүсгэж, үр нөлөөг бууруулж байна.
- Төрийн өмчит хуулийн этгээдүүд аудитын хамрах хугацаанд нийт 1,476.1 сая төгрөгийн ашигтай ажилласан ч санхүүгийн харьцаа үзүүлэлтүүдийг бүрэн хангаж чадахгүй байна.
- Бүхий л хяналтын хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх шаардлагатай байна.

Аудитаар илэрсэн 3.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн 2 акт тогтоосон.

#### **САНАЛ:**

Үндэсний аудитын газарт:

Орхон АЗЗА ТӨХК-ийн хөрөнгийн нийт дүн, орлогын хэмжээ нь харьцангуй бага гол орлогоо улсын чанартай авто зам, засвар арчлалтай холбоотойгоор Зам, тээврийн яамтай байгуулсан гэрээний хүрээнд бүрдүүлдэг. Хувьцаат компанийн бүтэц, засаглал нь оновчгүй, ТУЗ-ийн зардал нь үр ашиггүй, хуулийн хүрээн дэх шат дамжлага төдий байгаа тул зохион байгуулалтыг өөрчилж, зардлын хяналт, үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой байна.

АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

ТАЙЛАНГ БИЧСЭН.



**ХАВСРАЛТУУД:****Хавсралт 1. ЭДЦС ТӨХК-д хийсэн засаглалын үнэлгээ**

Но.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Тайлбар
<b>А</b>	<b>Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал</b>				<b>Нийт 40 онооноос 23 оноо</b>
A.1	ХЭ-гчид компанийн засаглалын кодекст заасан үндсэн болон бусад эрхүүдийг бүрэн эдлэх нөхцөл боломжоор хангагдсан уу?			2	хангагдсан
A.2	Компанийн засаглалын кодекст заасан компанийн чухал асуудлуудыг ХЭХ-аар шийдвэрлэж байхаар дүрэмдээ тусгасан уу?			2	КЗКодекст заасан эрхийг компанийн дүрэмдээ тусгасан
A.3	Компани хийж буй их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хянах боломж нөхцөлөөр ХЭ-гчдийг хангадаг уу?		1		Компанийн дүрмийн 6.1.12,6.1.13-д их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах талаар тусгасан
A.4	ТУЗ-ийн гишүүний нэрийг дэвшүүлэх болон чөлөөлөх эрхийг хэрэгжүүлэх боломж нөхцөлөөр ХЭгчдийг хангасан уу?			2	хангагдсан
A.5	ХЭ-гчид компанийг хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхтэй юу?				хаалттай ХК
A.6	Ногдол ашгийн бодлого, ногдол ашиг тодорхойлох журамтай юу?	0			байхгүй
A.7	Сүүлийн 3 жилд ногдол ашиг хуваарилсан уу?			2	тийм
A.8	ХЭХ-ыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор багтаан хуралдуулдаг уу?			2	тийм
A.9	ХЭХ-ыг зарлан хуралдуулах журамтай юу?	0			байхгүй
A.10	ХЭХ-ын зарыг зохистой хэлбэрээр хүргэдэг үү?		1		Зарыг албан бичгээр ЭХЯ, СЗХ-нд албан бичгээр хүргүүлдэг
A.11	ХЭХ-ын материалыг зохистой хэлбэрээр хүргэж, хурлаар хэлэлцэх асуудлыг судалж танилцах нөхцөл бололцоогоор хангадаг уу?			2	Хурлын тов баталсан ТУЗ-ын тогтоолд хэлэлцэх асуудлын жагсаалт, санал авах хуудасны загвар, хурлын мэдэгдэл, хурлын зарыг баталсан байдаг. Албан бичгээр ТУЗ-ын тогтоолыг хавсралтын хамт хүргүүлдэг. Материалыг ТӨБЗГ, ЭХЯ-нд хүргүүлдэг.
A.12	Компанийн удирдах албаны хүмүүст олгосон шагнал урамшууллыг ХЭХд тайлагнаж хэлэлцдэг үү?	0			үгүй. Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээг дүгнэж цалин урамшууллыг хэлэлцдэг
A.13	Компанийн саналын эрхтэй хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигч нь ХЭХ-ын хөтөлбөрийн хэлэлцэх асуудалд нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой юу?	0			боломжгүй
A.14	ХЭХ-ыг долоо хоногийн амралтын өдрүүдэд зохион байгуулдаг уу?	0			ажлын өдрүүдэд хуралддаг
A.15	Хурлаар хэлэлцэж буй асуудал тус бүрээр санал хураалт явуулдаг уу?			2	явуулдаг

A.16	ХЭ-гчид ХЭХ дээр хөндлөнгийн аудиторроос асуулт асууж, тайлбар авах боломжоор хангагддаг уу?	0			хөндлөнгийн аудиторыг оролцуулдаггүй
A.17	ХЭХ-д компанийн жилийн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулж, хэлэлцүүлэг хийх боломж олгодог уу?			2	тийм
A.18	ХЭ-гчдээс ХЭХ дээр асуулт тавьж хариулт авах хугацааг хурлын хэлэлцэх асуудалд оруулдаг уу?			2	ХЭХ-ын дэг"-д асуудал тус бүрийн дараа асуулт хариултын цагийг тусад нь заасан байдаг
A.19	ХЭХ-ын тооллогын комисс томилогдож, зохих журмын дагуу ажилладаг уу?			2	ХЭХ хуралдуулах ТУЗ-ын тогтоолоор компанийн албан хаагчдаас тооллогын комисс томилж ажиллуулдаг. Ерөнхий инженер, ЗУХ-ийн дарга, ГЗ-ийн нарийн бичиг голчлон ажилладаг
A.20	ХЭХ-ын тэмдэглэлийг хуульд заасан хугацаанд багтаан гаргаж хурлын даргын гарын үсэг, тамгаар баталгаажуулдаг уу?		1		ХЭХ-ийн хурлын тэмдэглэлийг ЭХЯ дээр гаргадаг. Хуулийн этгээдэд тогтоолоос өөрт хамааралтай хэсгийг өгдөг
<b>Б</b>	<b>Хувьцаа эзэмшигчдийн ижил тэгш байдал</b>	<b>Үгүй 0</b>	<b>Зарим 1</b>	<b>Бүрэн 2</b>	<b>Нийт 16 онооноос 6 оноо</b>
Б.1	ХЭ-гчдийн гомдлыг хүлээж авах, барагдуулах асуудлыг холбогдох дүрэм журамд тусгасан уу?	0			байхгүй
Б.2	Ногдол ашгийг зохих бодлого журмын дагуу цаг хугацаанд нь ХЭГчдэд хялбар арга хэлбэрээр хуваарилдаг уу?		1		ногдол ашгийн бодлого, журам байхгүй. Ногдол ашгийг хуваарилдаг
Б.3	ХЭ-гч хүссэн тохиолдолд холбогдох мэдээллээр хангах асуудлыг холбогдох журамд тусгасан уу?	0			байхгүй
Б.4	ХЭХ-ын өмнө ХЭ-гч хүссэн тохиолдолд ХЭ-гчдийн бүртгэлтэй танилцах эрхтэй байх талаар журамд тусгасан уу?	0			ХЭ бүртгэл байхгүй
Б.5	ХЭХ-аас гаргасан шийдвэрийг ХЭГчдэд танилцуулах нөхцөл боломжоор хангасан уу?		1		ХЭХ-аас гарсан шийдвэрийг ЭХЯ-аас ирүүлдэг.
Б.6	ХЭХ хуралдуулах шийдвэр гаргаснаас хойш хурлын товыг өөрчлөхгүй байх талаар зохицуулсан зохицуулалтыг мөрдөж ажилладаг уу?			2	Компанийн дүрэмд заасны дагуу хугацааг мөрдөж ажилладаг
Б.7	ХЭХ-д ХЭ-гч биеэр оролцож чадахгүй тохиолдолд хэрхэн санал өгөх талаар холбогдох журамд тодорхой тусгасан уу?		1		Компанийн тухай хуулиар зохицуулдаг
Б.8	ХЭ-гч мэдээлэл авах хүсэлтээ цахим шуудангаар ирүүлсэн тохиолдолд түүний шаардсан мэдээллийг цахимаар хүргүүлэх асуудал журамд тусгагдсан уу?		1		Компанийн тухай хуулиар зохицуулдаг
Б.9	Бүртгэлийн өдрөөс хойш хувьцаагаа бусдад шилжүүлсэн этгээд шинэ эзэмшигчид ХЭХ-д оролцох итгэмжлэл олгох, эсхүл шинэ эзэмшигчийн өгсөн зааврын дагуу санал өгөх эрхийг хэрэгжүүлж ажилладаг уу?				хаалттай ХК
<b>В</b>	<b>Оролцогч талуудын харилцаа</b>	<b>Үгүй 0</b>	<b>Зарим 1</b>	<b>Бүрэн 2</b>	<b>Нийт 20 онооноос 15 оноо</b>

B.1	Компанид оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан бодлого, журам байдаг уу?			2	ЭХЗХ-ний 2018.10.11-ний 291 тушаалаар баталсан "Аж ахуйн харилцааны дүрэм"-ийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын харилцааг зохицуулах журмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг
B.2	Оролцогч талуудын санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч барагдуулах механизм бий юу?			2	ГЗ 2020.10.01-ний А/76 тушаалаар баталсан Шуурхай ажиллагааны хяналт мэдээллийн системийг мөрдөх журмын дагуу өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажилладаг. ГЗ-ийн 2017.6.20-ны А/57 Эрчим хүч хэрэглэгдчээс гаргасан өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээж авч шийдвэрлэх журам
B.3	Компанийн хэмжээнд гарч буй хууль бус болон ёс зүйгүй практик ажиллагааны талаар ТУЗ-тэй шууд холбоо барих механизм бий юу?	0			үгүй
B.4	Компани гаргаж буй шийдвэрүүдээ оролцогч талуудын сонирхол, эрх ашгийг харгалзан гаргадаг уу?	0			Баталсан журам, дүрэмд энэ талаар тусгаагүй, зохицуулалтгүй
B.5	Компани нь оролцогч талуудыг шаардлагатай мэдээллээр хангаж ажилладаг уу?			2	Шуурхай ажиллагааны хяналт мэдээллийн системийг мөрдөх журмын дагуу хэрэглэгчдээс ирсэн санал хүсэлтийг хүлээн авч мэдээллээр хангаж ажилладаг
B.6	Компани оролцогчидтой гэрээ байгуулах явцад нь хяналт тавих, дүгнэх, хариуцлага тооцох үйл ажиллагааг зохицуулсан журамтай юу?			2	ГЗ-ийн 2019.09.18-ны А/101 тушаалаар баталсан "Компанийн бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтэнд хяналт тавих журам, ГЗ-ийн 2020.02.07-ны А/17 тушаалаар Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ, түүнтэй холбогдон гарах харилцааг зохицуулах журам", ГЗ-ийн 2020.01.27-ний А/08 тушаалаар баталсан ЭДЦС ТӨХК-ийн хувь хүн, гадны байгууллагын хүсэлтээр автомашин, тусгай зориулалтын техникийг хөлсөөр ажиллуулах журам"
B.7	Компанийн бэлтгэн нийлүүлэгчид, худалдан авагчид, гэрээ гүйцэтгэгч зэрэг гол гол харилцагч талуудын хэдэн хувь нь 3-аас дээш жил хамтарсан түншүүд байдаг вэ?			2	100%
B.8	Компани нь оролцогч талуудтай холбоотой чухал үйл явдал /томоохон түншээ алдах, гэрээ цуцлагдах г.м/-ын мэдээллийг ХЭ-гч, ХО-гчдад мэдээлдэг үү?		1		Томоохон түншээ алдах, гэрээ цуцлагдаж байгаагүй. Эдгээр үйл явдал тохиолдвол мэдээллэнэ.
B.9	Компанийн ажилтнуудын санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, тэдний нийгмийн асуудал, мэргэжил мэргэшлийг дээшлүүлэх төлөвлөгөөтэй ажилладаг уу?			2	ГЗ-ийн 2018.6.26-ны Компанийн ажилтнуудыг сургах, дадлаажуулах, давтан сургах, мэргэшүүлэх, ажлыг зохион байгуулах журмын дагуу ажилладаг. Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтын гэрээ байгуулж ажилладаг
B.10	Компани дотооддоо үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай байх бодлогыг дэмжиж ажилладаг уу?			2	Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтын гэрээ байгуулж ажилладаг
<b>Г</b>	<b>Мэдээллийн ил тод, нээлттэй байдал</b>	<b>Үгүй 0</b>	<b>Зарим 1</b>	<b>Бүрэн 2</b>	<b>Нийт 20 онооноос 12 оноо</b>

Г.1	Компани мэдээллийн журамтай юу?	0			байхгүй
Г.2	Хөрөнгө оруулагчтай харилцах болон нийтэд мэдээлэл хүргэх зохистой тогтолцоог бүрдүүлсэн үү?	0			үгүй
Г.3	Хувьцаа эзэмшигчидтэй харилцах, нийтэд мэдээлэл түгээх, СЗХ болон МХБ-ээс тогтоосон журмын дагуу мэдээллийг тогтмол хүргэх чиг үүрэг бүхий ажилтантай юу?	0			үгүй
Г.4	ТУЗ-ийн болон компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмыг өөрийн цахим хуудас дээр байршуулан нийтэд мэдээлж ажилладаг уу?		1		Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм, Ажилтны ёс зүйн дүрэм, Компанийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих журам, 35МВт өргөтгөлийн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах журам байршуулсан
Г.5	Компанийн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь өнөөгийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчдын хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэж чадсан уу?		1		ТУЗ-ын хурлын тэмдэглэл 2016 оноос өөр байхгүй, дүрэм журмууд хангалтгүй, Санхүүгийн тайлан, үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт 2018-2021 он байршуулсан, мэдээлэл хангалтгүй
Г.6	ХЭ-гчдийн ээлжит хурлын зар мэдэгдлийг СЗХ, МХБ болон ХЭгчдэд цаг хугацаанд нь хүргүүлсэн үү?		1		ХЭХ-ын зарыг СЗХ, ЭХЯ-нд албан бичгээр хүргүүлдэг
Г.7	ХЭ-гчдийн ээлжит хурлын шийдвэрийг СЗХ, МХБ болон ХЭгчдэд цаг хугацаанд нь хүргүүлсэн үү?		1		Хурлын шийдвэрийг хүргүүлдэггүй. ЭХЯ-аас ирүүлдэг
Г.8	Компани олон улсын стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг баталж, мөрдөн ажилладаг уу?			2	НБББББ-тэй
Г.9	Компанийн санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд гарган СЗХ, МХБ-д хүргүүлж, нийтэд мэдээлдэг үү?		1		МХБ-ийн сайтад жил, улирлаар хүргүүлж мэдээллэж ажилладаг
Г.10	Жилийн үйл ажиллагааны тайланг холбогдох хууль журмын дагуу гаргаж мэдээлдэг үү?			2	Компанийн дүрэмд заасны дагуу үйл ажиллагааны тайланг гаргаж ТУЗ-д танилцуулдаг
Г.11	Жилийн үйл ажиллагааны тайланд компанийн (санхүүгийн бус) үйл ажиллагаа, түүний өрсөлдөх чадвар ямар байгаа болон бусад санхүүгийн холбогдолгүй асуудлын талаар тодорхой тусгадаг уу?			2	тусгадаг
Г.12	Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл ил тод байдаг уу?	0			МХБ-ийн сайтад ТӨХ 100% гэсэн бүртгэлтэй байдаг
Г.13	Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын хувьцааны эзэмшлийн талаарх мэдээлэл ил тод байдаг уу?		1		Компанийн сайтад Гүйцэтгэх захирал болон 2 дэд захирлын мэдээлэл байдаг
Г.14	Тухайн жилийн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний хэлцлийн талаар нийтэд мэдээлдэг үү?				Их хэмжээний хэлцэл хийдэггүй
Г.15	Компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийн талаарх мэдээллийг жилийн тайланд тусгадаг уу?	0			үгүй

Г.16	Компанийн эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын талаарх мэдээллийг жилийн тайланд тусгадаг уу?	0			үгүй
Г.17	Компанийн засаглалын тайлан, КЗын кодексийг хэрэгжүүлж байгаа эсэх тухай мэдэгдлийг жилийн үйл ажиллагааны тайланд тусгадаг уу?	0			үгүй
Г.18	Компанийн чухал үйл явдал, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх мэдээллийг тухай бүр шуурхай хүргэх талаар холбогдох журамд тусгаж, хэрэгжүүлдэг үү?	0			үгүй
Г.19	Компани дотоод мэдээлэл ашиглан арилжаа хийж байгаа эсэхэд хяналт тавих тогтолцоог бүрдүүлсэн үү?	0			үгүй
Г.20	Хөндлөнгийн аудиторыг хугацаанаас нь өмнө сольсон тохиолдолд энэ талаар нийтэд мэдээлэх тухай холбогдох журамд тусгаж ажилладаг уу?	0			үгүй
<b>Д</b>	<b>Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх хороод</b>	<b>Үгүй 0</b>	<b>Зарим 1</b>	<b>Бүрэн 2</b>	<b>Нийт 60 онооноос 26 оноо</b>
Д.1	ТУЗ-ийн үйл ажиллагааг зохицуулсан журамтай юу?			2	ТУЗ-ийн 2012.11.29-ний 16 дугаар тогтоолоо ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баталсан
Д.2	ТУЗ-ийн гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлсон уу?			2	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Компанийн дүрэмд тусгасан байдаг
Д.3	ТУЗ нь компанийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлж, удирдамж зөвлөмжөөр хангаж ажилладаг уу?		1		ТУЗ-аас компанийн жилийн техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталдаг
Д.4	ТУЗ-ийн даргыг компанийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдээс сонгохгүй байх зохицуулалтыг холбогдох журамд тусгасан уу?	0			үгүй
Д.5	ТУЗ-ийн бүрэлдэхүүн хангалттай тооны хараат бус гишүүдтэй юу?		1		үгүй нийт 8 гишүүнтэй. 2 хараат бус гишүүнтэй. 2021 онд хэсэг хугацаанд 8 гишүүнтэй ажилласан.
Д.6	ТУЗ-ийн хурлын жилийн төлөвлөгөө гаргаж ажилладаг уу?			2	ТУЗ-ын жилийн ажлын төлөвлөгөө гаргаж ажилладаг
Д.7	ТУЗ-ийн гишүүд ХЭХ-д биечлэн оролцож, ХЭ-гчдийн асуултад хариулт өгдөг байх үүргийг холбогдох журамд тусгасан уу?	0			ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд байдаггүй
Д.8	Хамгийн сүүлийн ХЭХ-д ТУЗ-ийн гишүүдийн хэдэн хувь оролцсон бэ?		1		Аудитын хорооны дарга, ТУЗ-ийн дарга оролцсон
Д.9	Орон тооны ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай юу?			2	хангамжийн нягтлан бодогч ТУЗ-ийн нарийн бичгийн үүргийн давхар гүйцэтгэдэг. ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд орон тооны байж болно гэж тусгасан
Д.10	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх үүрэг, хариуцлага нь тодорхой байдаг уу?			2	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Компанийн дүрэмд тусгасан байдаг
Д.11	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин урамшуулал нь бусад эрх бүхий албан тушаалтнытай ижил хэмжээнд тогтоогдсон уу?	0			Бага тогтоогддог
Д.12	ТУЗ-ийн дэргэд нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороотой юу?			2	тийм

Д.13	Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны үйл ажиллагааг зохицуулсан журамтай юу?			2	тийм
Д.14	ТУЗ-ийн нэр дэвшүүлэх үйл ажиллагаа нь зохих журмын дагуу явагддаг уу?		1		тийм ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланд нэр дэвшүүлэх хорооны тайланг тусгадаг
Д.15	ТУЗ-д нэр дэвшүүлэх, нэр дэвшигчдээс сонголт хийх, санал хураах асуудлыг журамд бүрэн, ойлгомжтой тусгаж, журмаа ил тод болгосон уу?		1		ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны журамд тусгасан байдаг. Журам ил тод бус
Д.16	Цалин урамшууллын хороо нь ТУЗийн гишүүд болон гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтанд олгох цалин урамшууллын бодлоготой юу?	0			байхгүй
Д.17	ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг үнэлж дүгнэдэг үү?			2	ГЗ-ийн үйл ажиллагааг контрактын гэрээгээр ТУЗ, ХЭХ-р дүгнэдэг. ТУЗ-ын ажлын тайлан, төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн биелэлтийг ХЭХ-д танилцуулдаг
Д.18	Тайлангийн жил дууссаны дараа ТУЗ-ийн гишүүн бүрийн үйл ажиллагаанд дүгнэлт өгч, урамшууллын хэмжээг тогтоодог уу?	0			үгүй
Д.19	ТУЗ-ийн дэргэд Аудитын хороотой юу?			2	тийм
Д.20	Аудит, цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хорооны дарга нь хараат бус гишүүн байдаг уу?		1		Аудитын хорооны дарга хараат бус, бусад хороодын дарга нар хараат
Д.21	Аудитын хороо нь компанийн санхүүгийн тайланг нягтлан шалгасан талаар дүнг хэлэлцэж дүгнэлт өгдөг үү?			2	тийм
Д.22	Аудитын хороо нь компанийн дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоонд үнэлэлт дүгнэлт өгсөн үү?	0			үгүй
Д.23	ТУЗ-өөс томилогддог дотоод аудитын албатай юу?	0			үгүй
Д.24	Дотоод аудитын албаны тайланг ТУЗ хэлэлцэж, дүгнэлт гаргасан уу?	0			үгүй
Д.25	Хөндлөнгийн аудиторыг сонгох ажиллагааг зохицуулах бодлого журамтай юу?	0			байхгүй
Д.26	Аудитын хороо нь хөндлөнгийн аудиторыг нэр дэвшүүлж ТУЗ-д танилцуулж ажилладаг уу?				Төрийн аудитын тухай хуулиар сонгогдсон хуулийн этгээдээр хөндлөнгийн аудитыг томилдог. Сольдоггүй
Д.27	Хөндлөнгийн аудиторыг сонгон шалгаруулсан байдал, түүний бие даасан, хараат бус байдлыг батлах баримт мэдээллийг ХЭХ-д танилцуулдаг уу?				Төрийн аудитын тухай хуулиар сонгогдсон хуулийн этгээдээр хөндлөнгийн аудитыг томилдог. Томилогдсон аудитын компанийн тайланг танилцуулдаг
Д.28	ТУЗ-ийн хороо бүр тогтмол хуралддаг уу?	0			үгүй
Д.29	ТУЗ-ийн хороо бүр тайлан гаргадаг уу?		1		ТУЗ-ийн жилийн үйл ажиллагааны тайланд хороо тус бүрээр хийсэн ажлыг дурддаг
Д.30	ТУЗ-ийн ёс зүйн кодексийг батлан мөрддөг үү?	0			үгүй
<b>Е</b>	<b>Гүйцэтгэх удирдлага</b>				<b>Нийт 20 онооноос 8 оноо</b>

		Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	
E.1	Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг зохицуулсан тусгай журам заавартай юу?			2	Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг Менежментийн гэрээгээр зохицуулдаг.
E.2	Гүйцэтгэх удирдлага холбогдох журмын дагуу үйл ажиллагааны үр дүнг тогтмол тайлагнадаг уу?			2	Гүйцэтгэх удирдлага нь компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн үр дүнг тайлагнадаг
E.3	ТУЗ-өөс удирдлагын багийн үйл ажиллагааг үнэлэх дүгнэх журмыг боловсруулсан уу?	0			үгүй
E.4	Компани дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын бодлоготой юу?		1		Гүйцэтгэх захирлын 2021.09.07-ны А/80 тушаалаар баталсан "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай
E.5	Гүйцэтгэх удирдлага сонирхлын зерчил бүхий аливаа үйл ажиллагаанаас зайлсхийх талаар зохицуулсан зохицуулалтыг холбогдох дүрэм, журамд тусгасан уу?	0			үгүй
E.6	Нийтэд нээлттэй бус дотоод мэдээллийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах, задруулахыг хориглох хяналт зохицуулалтыг хэрэгжүүлдэг үү?	0			үгүй
E.7	Гүйцэтгэх удирдлагын тухайн компанийн үнэт цаасны арилжаанд оролцож буй байдлыг ил тод болгодог уу?	0			үгүй
E.8	Компани ёс зүйн дүрэмтэй юу?		1		Гүйцэтгэх захирлын 2019.11.06-ны өдрийн А/108 тушаалаар баталсан "Ажилтнуудын ёс зүйн дүрэм" байдаг
E.9	Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллыг нийтэд мэдээлдэг үү?	0			үгүй
E.10	Удирдлагын залгамж халааны бодлоготой юу?			2	Гүйцэтгэх захирлын 2018.06.26-ний А/87 тушаалаар баталсан "Компанийн ажилтнуудыг сургах, дадлагажуулах, давтан сургах, мэргэшүүлэх, ажлыг зохион байгуулах журам"-тай

**Хавсралт 2. ЭДЦС ТӨХК, Орхон АЗЗА ТӨХК-ийн техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний хэвтээ шинжилгээ.**

ЭДЦС ТӨХК-ийн техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний хэвтээ шинжилгээ													
Д/д	Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Хэмжих нэгж	2019 оны төлөвлөгөө	2020 оны төлөвлөгөө			2021 оны төлөвлөгөө		Өөрчлөлт			
					Анх баталсан 2020.01.08, 27	Тодотгол 2020.09.18, 182	Тодотгол 2020.11.12, 237	Анх баталсан 2021.01.20, А/11	Тодотгосон 2021.09.27, А/203	2020-2019	2021-2019	2021-2020	2021-2021
					х	1	2	3	4	5	6	7=4-1	8=6-1
1	Боловсруулсан	ЦЭХ	сая.квтц	160.4	162.8	158.9	158.9	281.8	265.5	-1.5	105.1	106.6	-16.3
		ДЭХ	мян.Гкал	595.4	611.6	612.9	612.9	633.1	651.0	17.5	55.6	38.1	17.9
	Түгээсэн	ЦЭХ	сая.квтц	129.4	131.7	129.2	129.2	238.9	223.5	-0.1	94.2	94.3	-15.4
		ДЭХ	мян.Гкал	567.9	583.9	586.7	586.7	605.5	612.1	18.8	44.2	25.4	6.6
2	Нийт орлого		сая.төг	38,112.0	44,314.3	44,726.7	42,564.9	47,258.0	46,682.6	4,452.9	8,570.6	4,117.7	-575.4
	Үүнээс:	Борлуулалтын орлого	сая.төг	36,632.5	42,846.8	43,259.2	41,097.4	45,790.5	45,215.1	4,465.0	8,582.7	4,117.7	-575.4
		Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	1,479.6	1,467.5	1,467.5	1,467.5	1,467.5	1,467.5	-12.1	-12.1	0.0	0.0
3	Нийт зардал		сая.төг	40,510.9	45,764.9	44,270.0	42,564.9	53,253.3	52,806.7	2,054.1	12,295.9	10,241.8	-446.6
4	Татварын өмнөх ашиг/алдагдал		сая.төг	-2,398.8	-1,450.6	456.7	0.0	-5,995.3	-6,124.1	2,398.8	-3,725.3	-6,124.1	-128.8
5	Татварын дараах ашиг/алдагдал		сая.төг	-2,398.8	-1,450.6	454.0	0.0	-5,995.3	-6,124.6	2,398.8	-3,725.8	-6,124.6	-129.3
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал		төг	1.06	1.03	0.99	1.00	0.89	1.13	-0.06	0.07	0.13	0.24
7	Нийт авлага		сая.төг	7,357.8	7,157.8	5,840.6	5,511.3	6,429.0	6,429.0	-1,846.6	-928.8	917.8	0.0
8	Нийт өглөг		сая.төг	10,597.3	10,300.0	8,316.0	7,657.4	9,957.5	153,258.6	-2,939.9	142,661.3	145,601.2	143,301.1
	Үүнээс:	Богино хугацаат өр төлбөр	сая.төг	10,597.3	10,300.0	2,640.2	2,140.0	5,781.7	5,781.7	-8,457.3	-4,815.6	3,641.7	0.0
		Урт хугацаат өр төлбөр	сая.төг	0.0	0.0	5,675.8	5,517.4	4,175.8	147,476.9	5,517.4	147,476.9	141,959.5	143,301.1
9	Нийт ажиллагсдын тоо		хүн	459.0	450.0	450.0	450.0	450.0	450.0	-9.0	-9.0	0.0	0.0
10	Нийт цалингийн сан		сая.төг	10,898.2	11,709.8	11,709.8	11,619.8	11,650.7	11,650.7	721.6	752.5	30.9	0.0
11	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт		сая.төг	5,381.8	5,749.9	5,600.9	5,575.9	7,092.9	7,092.9	194.2	1,711.2	1,517.0	0.0
Орхон АЗЗА ТӨХК-ийн техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний хэвтээ шинжилгээ													
Д/д	Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Хэмжих нэгж	2019 оны төлөвлөгөө	2020 оны төлөвлөгөө			2021 оны төлөвлөгөө		Өөрчлөлт			
					2			3		2020-2019	2021-2019	2021-2020	
					х	1	2	3	4=2-1	5=3-1	6=3-2		
1	Нийт орлого		сая.төг	985.5	1,157.7			1,337.5		172.2	352.1	179.9	
	Үүнээс:	Улсын чанартай АЗЗА	сая.төг	799.0	782.4			1,121.0		-16.6	322.0	338.6	
		Бусад	сая.төг	186.5	375.3			216.5		188.8	30.1	-158.8	
2	Нийт зардал		сая.төг	962.8	1,134.6			1,284.4		171.7	321.6	149.8	
3	Татварын өмнөх ашиг/алдагдал		сая.төг	22.6	23.1			53.1		0.5	30.5	30.0	
4	Татварын дараах ашиг/алдагдал		сая.төг	20.4	20.8			47.8		0.4	27.5	27.0	
5	Шимтгэл татвар, хураамж, төлбөр		сая.төг	185.0	178.1			266.3		-6.9	81.3	88.2	
6	Төрийн өмчийн ногдол ашиг		сая.төг	0.0	4.1			4.8		4.1	4.8	0.7	
7	Нийт авлага		сая.төг	171.0	160.0			176.8		-11.0	5.8	16.8	
8	Нийт өглөг		сая.төг	756.9	726.9			726.9		-30.0	-30.0	0.0	
	Үүнээс:	Богино хугацаат өр төлбөр	сая.төг	130.0	100.0			100.0		-30.0	-30.0	0.0	
		Урт хугацаат өр төлбөр	сая.төг	626.9	626.9			626.9		0.0	0.0	0.0	
9	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал		төг	0.98	0.98			0.96		0.00	-0.02	-0.02	
10	Хөрөнгө оруулалт		сая.төг	10.7	8.0			25.4		-2.7	14.7	17.4	
11	Нийт ажиллагсдын тоо		хүн	38.0	38.0			39.0		0.0	1.0	1.0	
12	Нийт цалингийн сан		сая.төг	359.3	406.0			419.3		46.7	60.0	13.3	

Хавсралт 3. ЭДЦС ТӨХК, Орхон АЗЗА ТӨХК-ийн эрсдэлийн шинжилгээ

3.1 Орхон АЗЗА ТӨХК

№	Харьцаа үзүүлэлт	Томъёо	2018 он		2019 он		2020 он		2021 он		Эрсдэлийн түвшин		
			Үзүүлэлт	Эрсдэлийн түвшин /оноо/	Бага /1 оноо/	Дунд /3 оноо/	Өндөр /5 оноо/						
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАРЬЦАА</b>													
1	Бараа материалын эргэц /удаа/	Борлуулалтын өртөг/Дундаж бараа материал	5.51	1	28.62	1	17.12	1	8.34	1	5.00-10.00	2.00-4.99	<1.99
2	Бараа материалын насжилт /хоног/	360/Бараа материалын эргэц	65.38	1	12.58	1	21.03	1	43.17	1	30-70	71-90	>90
3	Авлагын эргэц /удаа/	Борлуулалтын орлого/Дундаж авлага	3.72	3	5.52	1	6.11	1	6.56	1	5.00-10.00	2.00-4.99	<1.99
4	Авлагын эргэц /хоног/	360/Авлагын эргэц-удаа	96.74	5	65.27	1	58.94	1	54.86	1	30-70	71-90	>90
5	Өглөгийн эргэц /удаа/	(Борлуулалтын өртөг + Бараа материалын эцсийн үлдэгдэл - Бараа материалын эхний үлдэгдэл)/Дундаж өглөг	2.34	3	4.61	3	6.14	1	7.44	1	5.00-10.00	2.00-4.99	<1.99
6	Өглөгийн эргэц /хоног/	360/Өглөгийн эргэц-удаа	153.93	5	78.05	3	58.59	1	48.37	1	30-70	71-90	>90
7	Ажлын капиталын эргэц	Борлуулалтын орлого/Ажлын капиталын дундаж* *Ажлын капитал = Эргэлтийн хөрөнгө - Эргэлтийн өр төлбөр	2.75	3	7.82	1	6.38	1	5.35	1	Өндөр байх тусам сайн /компанийн өмнөх онуудын үзүүлэлттэй харьцуулах/		
8	Үндсэн хөрөнгийн эргэц	Борлуулалтын орлого/Үндсэн хөрөнгийн дундаж	2.60	3	2.55	3	2.25	3	1.81	5			
9	Нийт хөрөнгийн эргэц	Борлуулалтын орлого/Нийт хөрөнгийн дундаж	0.83	1	1.04	1	1.18	1	1.15	1	>0.2	0.05-0.2	<0.05
<b>ХӨРВӨХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА</b>													
10	Эргэлтийн харьцаа	Нийт эргэлтийн хөрөнгө/ Богино хугацаат өр төлбөр	1.55	1	1.84	1	2.76	1	2.27	1	>1.5	1.0-1.5	<1.0
11	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа /ТТГЧХ/	(Эргэлтийн хөрөнгө - бараа материал)/ Богино хугацаат өр төлбөр	1.45	1	1.62	1	2.22	1	1.27	1	>1.0	0.8-1.0	<0.8
12	Бэлэн мөнгөний харьцаа	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгө/ Богино хугацаат өр төлбөр	0.59	5	0.52	5	0.72	3	0.28	5	>1.0	0.7-1.0	<0.7
13	Мөнгөн хөрөнгийн эргэлтийн мөчлөг /Үйл ажиллагааны мөчлөг/	Бараа материалын насжилт /хоног/ + Авлагын эргэц /хоног/ - Өглөгийн эргэц /хоног/	8.18	1	(0.20)	1	21.38	1	49.66	1	<60	60-90	>90
<b>ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ХАРЬЦАА</b>													
<b>Өр төлбөрийн харьцаа</b>													
14	Өр, нийт хөрөнгийн харьцаа	Нийт өр төлбөр/ Нийт хөрөнгө	0.78	5	0.77	5	0.76	5	0.77	5	<0.5	0.5-0.7	>0.7
15	Өр, капиталын харьцаа	Нийт өр төлбөр/ (Хүү төлдөг өр төлбөр* + Эздийн өмч) *Хүү төлдөг бүх урт ба богино хугацаат өр төлбөр	3.46	5	3.33	5	3.15	5	3.34	5	<0.7	0.7-0.9	>0.9
16	Өр, өөрийн хөрөнгийн харьцаа	Нийт өр төлбөр/ Эздийн өмч	3.46	5	3.33	5	3.15	5	3.34	5	<1.0	1.0-2.0	>2.0
17	Санхүүгийн хөшүүргийн харьцаа	Нийт хөрөнгийн дундаж/ Эздийн өмчийн дундаж	4.41	5	4.39	5	4.24	5	4.25	5	<2.0	2.0-3.0	>3.0
18	Өр, ЕВПДА-гийн харьцаа	Нийт өр төлбөр/ Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг	(3.13)	1	20.78	5	7.16	1	28.74	5	3.0-10.0	10.0-15.0	>15.0
<b>Төлбөрийн чадварын харьцаа</b>													
19	Хүү төлөх чадварын харьцаа	Хүү, татварын өмнөх ашиг/ Хүүний зардал *Хүү, татварын өмнөх ашиг ЕВIT = Нийт ашиг - Үйл ажиллагааны зардал	-	1	-	1	-	1	-	1	>3.0	1.5-3.0	<1.5

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашг

20	Тогтмол зардал төлөх чадварын харьцаа	(Хүү, татварын өмнөх ашиг+ Түрээсийн төлбөр)/ (Хүүний төлбөр+ Түрээсийн төлбөр)	-	1	-	1	-	1	-	1	>3.0	1.5-3.0	<1.5
<b>АШИГТ АЖИЛЛАГААНЫ ХАРЬЦАА</b>													
<b>Борлуулалтын орлогын өгөөж /return on sales/</b>													
21	Нийт ахиуц ашиг	Нийт ашиг/ Борлуулалтын орлого *Нийт ашиг = Борлуулалтын орлого- Борлуулалтын өртөг	(0.10)	5	0.15	5	0.22	5	0.15	5	0.5-0.7	0.3-0.49	<0.3
22	Үйл ажиллагааны ахиуц ашиг	Хүү, татварын өмнөх ашиг/ Борлуулалтын орлого *Хүү, татварын өмнөх ашиг EBIT = Нийт ашиг - Үйл ажиллагааны зардал	(0.32)	5	(0.00)	5	0.02	3	(0.03)	5	0.1-0.2	0.0-0.09	<0.0
23	Татварын өмнөх ахиуц ашиг	Татварын өмнөх ашиг/ Борлуулалтын орлого	(0.31)	5	0.00	3	0.03	3	0.00	3	0.1-0.2	0.0-0.09	<0.0
24	Цэвэр ахиуц ашиг	Цэвэр ашиг/ Борлуулалтын орлого	(0.31)	5	0.00	3	0.03	3	0.00	3	0.1-0.2	0.0-0.09	<0.0
<b>Хөрөнгө оруулалтын өгөөж /return on investment/</b>													
25	Хөрөнгийн өгөөж	Цэвэр ашиг/ Нийт хөрөнгийн дундаж	-25.87%	5	0.29%	3	3.09%	3	0.20%	3	3-8%	0-2.9%	<0%
26	Өөрийн хөрөнгийн өгөөж	Цэвэр ашиг/ Эздийн өмчийн дундаж	-114.05%	5	1.26%	3	13.11%	1	0.00%	5	5-10%	0-4.9%	<0%
<b>ЭРСДЭЛИЙН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ</b>				<b>3.31</b>		<b>2.77</b>		<b>2.23</b>		<b>2.77</b>			

3.2 ЭДЦС ТӨХК

№	Харьцаа үзүүлэлт	Томъёо	2018 он		2019 он		2020 он		2021 он		Эрсдэлийн түвшин		
			Үзүүлэлт	Эрсдэлийн түвшин /оноо/	Бага /1 оноо/	Дунд /3 оноо/	Өндөр /5 оноо/						
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАРЬЦАА</b>													
1	Бараа материалын эргэц /удаа/	Борлуулалтын өртөг/Дундаж бараа материал	14.16	1	12.19	1	11.30	1	15.72	1	5.00-10.00	2.00-4.99	<1.99
2	Бараа материалын насжилт /хоног/	360/Бараа материалын эргэц	25.42	1	29.53	1	31.85	1	22.89	1	30-70	71-90	>90
3	Авлагын эргэц /удаа/	Борлуулалтын орлого/Дундаж авлага	18.40	1	13.81	1	11.91	1	10.42	1	5.00-10.0	2.00-4.99	<1.99
4	Авлагын эргэц /хоног/	360/Авлагын эргэц-удаа	19.57	1	26.06	1	30.23	1	34.54	1	30-70	71-90	>90
5	Өглөгийн эргэц /удаа/	(Борлуулалтын өртөг + Бараа материалын эцсийн үлдэгдэл - Бараа материалын эхний үлдэгдэл)/Дундаж өглөг	164.35	1	202.04	1	65.46	1	26.82	1	5.00-10.0	2.00-4.99	<1.99
6	Өглөгийн эргэц /хоног/	360/Өглөгийн эргэц-удаа	2.19	1	1.78	1	5.50	1	13.42	1	30-70	71-90	>90
7	Ажлын капиталын эргэц	Борлуулалтын орлого/Ажлын капиталын дундаж* *Ажлын капитал = Эргэлтийн хөрөнгө - Эргэлтийн өр төлбөр	6.38	1	13.14	1	9.17	1	6.55	1	Өндөр байх тусам сайн /компанийн өмнөх онуудын үзүүлэлттэй харьцуулах/		
8	Үндсэн хөрөнгийн эргэц	Борлуулалтын орлого/Үндсэн хөрөнгийн дундаж	0.76	5	0.64	5	0.64	5	0.76	5			
9	Нийт хөрөнгийн эргэц	Борлуулалтын орлого/Нийт хөрөнгийн дундаж	0.55	1	0.44	1	0.44	1	0.52	1			

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашг

ХӨРВӨХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА													
10	Эргэлтийн харьцаа	Нийт эргэлтийн хөрөнгө/ Богино хугацаат өр төлбөр	3.99	1	1.13	3	8.85	1	3.48	1	>1.5	1.0-1.5	<1.0
11	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа /ТТГЧХ/	(Эргэлтийн хөрөнгө - бараа материал) Богино хугацаат өр төлбөр	2.53	1	0.68	5	5.65	1	2.60	1	>1.0	0.8-1.0	<0.8
12	Бэлэн мөнгөний харьцаа	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Богино хугацаат өр төлбөр	0.65	5	0.11	5	1.03	1	0.11	5	>1.0	0.7-1.0	<0.7
13	Мөнгөн хөрөнгийн эргэлтийн мөчлөг /Үйл ажиллагааны мөчлөг/	Бараа материалын насжилт /хоног/ + Авлагын эргэц /хоног/ – Өглөгийн эргэц /хоног/	42.80	1	53.82	1	56.58	1	44.01	1	<60	60-90	>90
ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ХАРЬЦАА													
Өр төлбөрийн харьцаа													
14	Өр, нийт хөрөнгийн харьцаа	Нийт өр төлбөр/ Нийт хөрөнгө	0.02	1	0.08	1	0.07	1	0.07	1	<0.5	0.5-0.7	>0.7
15	Өр, капиталын харьцаа	Нийт өр төлбөр/ (Хүү төлдөг өр төлбөр* + Эздийн өмч) *Хүү төлдөг бүх урт ба богино хугацаат өр төлбөр	0.02	1	0.08	1	0.07	1	0.08	1	<0.7	0.7-0.9	>0.9
16	Өр, өөрийн хөрөнгийн харьцаа	Нийт өр төлбөр/ Эздийн өмч	0.02	1	0.08	1	0.07	1	0.08	1	<1.0	1.0-2.0	>2.0
17	Санхүүгийн хөшүүргийн харьцаа	Нийт хөрөнгийн дундаж/ Эздийн өмчийн дундаж	1.03	1	1.05	1	1.08	1	1.08	1	<2.0	2.0-3.0	>3.0
18	Өр, ЕВТДА-гийн харьцаа	Нийт өр төлбөр/ Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг	0.47	1	1.44	1	1.36	1	1.49	1	3.0-10.0	10.0-15.0	>15.0
Төлбөрийн чадварын харьцаа													
19	Хүү төлөх чадварын харьцаа	Хүү, татварын өмнөх ашиг/ Хүүний зардал *Хүү, татварын өмнөх ашиг ЕВТ = Нийт ашиг - Үйл ажиллагааны зардал	-	1	-	1	-	1	-	1	>3.0	1.5-3.0	<1.5
20	Тогтмол зардал төлөх чадварын харьцаа	(Хүү, татварын өмнөх ашиг+ Түрээсийн төлбөр)/ (Хүүний төлбөр+ Түрээсийн төлбөр)	-	1	-	1	-	1	-	1	>3.0	1.5-3.0	<1.5
АШИГТ АЖИЛЛАГААНЫ ХАРЬЦАА													
Борлуулалтын орлогын өгөөж /return on sales/													
21	Нийт ахиуц ашиг	Нийт ашиг/ Борлуулалтын орлого *Нийт ашиг = Борлуулалтын орлого- Борлуулалтын өртөг Хүү, татварын өмнөх ашиг/ Борлуулалтын орлого	0.10	5	0.12	5	0.10	5	0.08	5	0.5-0.7	0.3-0.49	<0.3
22	Үйл ажиллагааны ахиуц ашиг	*Хүү, татварын өмнөх ашиг ЕВТ = Нийт ашиг - Үйл ажиллагааны зардал	(0.00)	5	(0.00)	5	(0.02)	5	(0.03)	5	0.1-0.2	0.0-0.09	<0.0
23	Татварын өмнөх ахиуц ашиг	Татварын өмнөх ашиг/ Борлуулалтын орлого	0.01	3	0.02	3	0.01	3	0.00	3	0.1-0.2	0.0-0.09	<0.0
24	Цэвэр ахиуц ашиг	Цэвэр ашиг/ Борлуулалтын орлого	0.01	3	0.02	3	0.01	3	0.00	3	0.1-0.2	0.0-0.09	<0.0
Хөрөнгө оруулалтын өгөөж /return on investment/													
25	Хөрөнгийн өгөөж	Цэвэр ашиг/ Нийт хөрөнгийн дундаж	0.53%	3	0.93%	3	0.58%	3	0.06%	3	3-8%	0-2.9%	<0%
26	Өөрийн хөрөнгийн өгөөж	Цэвэр ашиг/ Эздийн өмчийн дундаж	0.55%	3	0.98%	3	0.63%	3	0.00%	5	5-10%	0-4.9%	<0%
<b>ЭРСДЭЛИЙН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ</b>				<b>1.92</b>		<b>2.15</b>		<b>1.77</b>		<b>2.00</b>			

## Хавсралт 4. Санхүүгийн тайлангийн шинжилгээ – ЭДЦС ТӨХК, Орхон АЗЗА ТӨХК

## 4.1 ЭДЦС ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн шинжилгээ

№	Үзүүлэлт	томъёо	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
<b>Нэг. Төлбөрийн чадварын шинжилгээ</b>							
1	Цэвэр эргэлтийн хөрөнгө /сая. төг/	нийт ЭХ-БХӨТ	7,430.5	6,702.6	7,913.7	8,040.7	6,740.3
2	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	/МХ+ТБҮЦ+Авл/ : БХӨТ	12.68	27.22	18.27	4.53	2.22
3	Эргэлтийн харьцаа	Нийт ЭХ :БХӨТ	29.34	52.55	36.38	8.85	3.48
4	Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	Нийт ЭХ : балансын цэвэр дүн	0.18	0.08	0.09	0.10	0.10
5	Он дамжсан болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийн хувийн жин	t хэтэрсэн өр төлбөр : нийт Өр	0.00	0.00	0.00	0.00	0.00
<b>Хоёр. Санхүүгийн тогтвортой байдал.</b>							
1	Бие даах чадварын коэффициент	Өөрийн К : балансын цэвэр дүн	0.96	0.98	0.92	0.93	0.93
2	Санхүүгийн хамаарлын коэффициент	балансын цэвэр дүн : өөрийн К	1.04	1.02	1.08	1.07	1.08
5	Альтманы индекс	Z=3.3K1+1.0K2+0.6K3+1.4K4 + 1.2K5	92.4	396.3	232.7	51.6	19.9
<b>Гурав.Эргэцийн шинжилгээ</b>							
1	Авлагын эргэц /удаа/	БО : Авлагын дундаж	27.60	18.69	14.18	12.38	10.77
2	Авлагын эргэц/өдөр/	360 : Авл эргэц	13.04	19.26	25.39	29.07	33.44
3	Нөөцийн эргэц/удаа/	ББӨ : БМ ҮБЗ дундаж	14.33	14.16	12.19	11.30	15.72
4	Нөөцийн эргэц /өдөр/	360 : нөөц эргэц	25.12	25.42	29.53	31.85	22.89
5	Эргэлтийн хөрөнгийн эргэц /удаа/	БО : ЭХ-ийн дундаж	5.13	4.94	5.44	4.97	5.40
6	Эргэлтийн хөрөнгийн эргэц/ өдөр/	360 : ЭХ эргэц	70.11	72.89	66.17	72.45	66.63
7	Өглөгийн эргэц/удаа/	зээрлх худ Ав : өглөгийн дундаж	102.54	150.16	143.63	36.53	15.47
8	Өглөгийн эргэц /өдөр/	360 : өгл эргэц	3.51	2.40	2.51	9.85	23.27
9	Үйлдвэрлэлийн циклийн хугацаа /өдөр/	авл эргэц+нөөц эргэц	38.16	44.68	54.93	60.92	56.33
10	Санхүүгийн циклийн хугацаа/өдөр/	авл эргэц+нөөц эргэц -өгл эргэц	34.65	42.28	52.42	51.06	33.06
<b>Дөрөв.Бүтээмжийн шинжилгээ</b>							
1	Хөдөлмөрийн бүтээмж / сая.төг/	БО/Аж тоо	79.5	82.1	89.7	95.0	111.2
2	Үндсэн хөрөнгийн ачаалал	БО : ҮХ дундаж	0.51	0.48	0.49	0.50	0.59
3	Материал өгөмж	БО : БМУБЗ дундаж	15.88	16.00	14.19	13.10	17.62
4	Эдийн засгийн тогтвортой есөлтийн коэффициент	/Цэв ашиг- төлсөн ногд ашиг/ : бал дүн	0.00	0.00	0.01	0.01	0.00
5	Хөдөлмөрийн зардлын өрсөлдөх чадвар	нэмэгд өртөг : хөд зард	4.68	4.49	4.24	4.05	4.74
<b>Тав. Ашигт ажиллагааны шинжилгээ</b>							
1	Борлуулалтын ашигт ажиллагаа	Цэвэр орлого : нийт орлого	0.99	0.97	0.98	0.96	0.96
2	Өртгөөр тооцсон борлуулалтын ашигт ажиллагаа	Цэвэр орлого : ББӨ	1.10	1.08	1.14	1.12	1.08
3	Хөрөнгийн ашигт ажиллагаа	Цэвэр ашиг : Бал цэвэр дүн	0.00	0.00	0.01	0.01	0.00
4	Өөрийн капиталын ашигт ажиллагаа	Цэвэр ашиг : өөрийн К	0.00	0.00	0.01	0.01	0.00
<b>Зургаа. Эргэцийн шинжилгээ</b>							
1	Авлагын эргэц/өдөр/		13.04	19.26	25.39	29.07	33.44
2	Өглөгийн эргэц /өдөр/		3.51	2.40	2.51	9.85	23.27
1	Нөөцийн эргэц /өдөр/		25.12	25.42	29.53	31.85	22.89
2	Эргэлтийн хөрөнгийн эргэц/ өдөр/		70.11	72.89	66.17	72.45	66.63
1	Үйлдвэрлэлийн циклийн хугацаа		38.16	44.68	54.93	60.92	56.33
2	Санхүүгийн циклийн хугацаа		34.65	42.28	52.42	51.06	33.06
<b>1</b>	<b>Авлага</b>		<b>1411.8</b>	<b>2426.7</b>	<b>3318.3</b>	<b>3584.3</b>	<b>5709.1</b>
<b>2</b>	<b>Өглөг</b>		<b>262.2</b>	<b>130.0</b>	<b>223.7</b>	<b>1024.3</b>	<b>2712.9</b>

## 4.2 Орхон АЗЗА ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн шинжилгээ

№	Үзүүлэлт	томъёо	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
<b>Төлбөрийн чадварын шинжилгээ</b>							
1	Цэвэр эргэлтийн хөрөнгө /сая. төг/	нийт ЭХ-БХӨТ	610.8	130.8	159.5	218.6	217.4
1	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	/МХ+ТБҮЦ+Авл/ : БХӨТ	1.56	1.45	1.62	2.22	1.27
2	Эргэлтийн харьцаа	Нийт ЭХ :БХӨТ	2.48	1.55	1.84	2.76	2.27
3	Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	Нийт ЭХ : балансын цэвэр дүн	0.76	0.33	0.33	0.35	0.37
4	Он дамжсан болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийн хувийн жин	† хэтэрсэн өр төлбөр : нийт Өр	0.00	0.00	0.00	0.00	0.00
<b>Хоёр. Санхүүгийн тогтвортой байдал.</b>							
1	Бие даах чадварын коэффициент	Өөрийн К : балансын цэвэр дүн	0.23	0.22	0.23	0.24	0.23
2	Санхүүгийн хамаарлын коэффициент	балансын цэвэр дүн : өөрийн К	4.37	4.46	4.33	4.15	4.34
5	Альтманы индекс	$Z=3.3K1+1.0K2+0.6K3+1.4K4+1.2K5$	1.9	0.3	2.0	2.8	2.2
<b>Гурав.Эргэцийн шинжилгээ</b>							
1	Авлагын эргэц /удаа/	БО : Авлагын дундаж	3.32	3.72	5.52	6.11	6.56
2	Авлагын эргэц/өдөр/	360 : Авл эргэц	108.50	96.74	65.27	58.94	54.86
3	Нөөцийн эргэц/удаа/	ББӨ : БМ ҮБЗ дундаж	2.76	5.51	28.62	17.12	8.34
4	Нөөцийн эргэц /өдөр/	360 : нөөц эргэц	130.57	65.38	12.58	21.03	43.17
5	Эргэлтийн хөрөнгийн эргэц /удаа/	БО : ЭХ-ийн дундаж	1.44	1.47	3.16	3.49	3.19
6	Эргэлтийн хөрөнгийн эргэц/ өдөр/	360 : ЭХ эргэц	250.20	245.71	113.75	103.14	112.85
7	Өглөгийн эргэц/удаа/	зээрх худ Ав : өглөгийн дундаж	3.74	2.34	4.61	6.14	7.44
8	Өглөгийн эргэц /өдөр/	360 : өгл эргэц	96.21	153.93	78.05	58.59	48.37
9	Үйлдвэрлэлийн циклийн хугацаа /өдөр/	авл эргэц+нөөц эргэц	239.08	162.12	77.85	79.97	98.03
10	Санхүүгийн циклийн хугацаа/өдөр/	авл эргэц+нөөц эргэц -өгл эргэц	142.87	8.18	-0.20	21.38	49.66
<b>Дөрөв.Бүтээмжийн шинжилгээ</b>							
1	Хөдөлмөрийн бүтээмж / сая.төг/	БО/Аж тоо	30.1	26.8	29.9	31.7	29.9
2	Үндсэн хөрөнгийн ачаалал	БО : ҮХ дундаж	2.86	1.90	1.56	1.78	1.80
3	Материал өгөмж	БО : БМҮБЗ дундаж	3.53	5.02	33.61	22.01	9.78
4	Эдийн засгийн тогтвортой өсөлтийн коэффициент	/Цэв ашиг- төлсөн ногд ашиг/ : Бал дүн	0.07	-1.27	0.01	0.13	0.00
<b>Тав. Ашигт ажиллагааны шинжилгээ</b>							
1	Борлуулалтын ашигт ажиллагаа	Цэвэр орлого : нийт орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
2	Өртгөөр тооцсон борлуулалтын ашигт ажиллагаа	Цэвэр орлого : ББӨ	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	Хөрөнгийн ашигт ажиллагаа	Цэвэр ашиг : Бал цэвэр дүн	0.02	-0.29	0.00	0.03	0.00
4	Өөрийн капиталын ашигт ажиллагаа	Цэвэр ашиг : өөрийн К	0.07	-1.27	0.01	0.13	0.01
<b>Зургаа. Эргэцийн шинжилгээ</b>							
1	Авлагын эргэц/өдөр/		108.50	96.74	65.27	58.94	54.86
2	Өглөгийн эргэц /өдөр/		96.21	153.93	78.05	58.59	48.37
1	Нөөцийн эргэц /өдөр/		130.57	65.38	12.58	21.03	43.17
2	Эргэлтийн хөрөнгийн эргэц/ өдөр/		250.20	245.71	113.75	103.14	112.85
1	Үйлдвэрлэлийн циклийн хугацаа		239.08	162.12	77.85	79.97	98.03
2	Санхүүгийн циклийн хугацаа		142.87	8.18	-0.20	21.38	49.66
1	<b>Авлага</b>		<b>344.5</b>	<b>203.7</b>	<b>208.1</b>	<b>187.0</b>	<b>168.7</b>
2	<b>Өглөг</b>		<b>412.5</b>	<b>238.3</b>	<b>189.0</b>	<b>124.1</b>	<b>171.5</b>

**Хавсралт 5. Техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлт – ЭДЦС ТӨХК, Орхон АЗЗА ТӨХК /2019-2022 он/**

**5.1 ЭДЦС ТӨХК-ийн техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлт**

Д/д	Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2019		Зөрүү	2020		Зөрүү	2021		Зөрүү	
			Төл	Гүйц		Төл	Гүйц		Төл	Гүйц		
			х	1		2	3		4	5		6
1	Боловсруулсан	ЦЭХ	сая.квтц	160.4	163.4	-3.0	158.9	158.2	0.7	265.5	271.0	-5.5
		ДЭХ	мян.Гкал	595.4	604.4	-9.0	612.9	620.3	-7.4	651.0	657.8	-6.8
	Түгээсэн	ЦЭХ	сая.квтц	129.4	133.7	-4.3	129.2	129.0	0.2	223.5	230.8	-7.2
		ДЭХ	мян.Гкал	567.9	580.8	-12.9	586.7	589.6	-2.9	612.1	616.0	-3.8
2	Нийт орлого		сая.төг	38,112.0	40,723.0	-2,611.0	42,564.9	42,737.6	-172.7	46,682.6	50,028.9	-3,346.3
	Үүнээс:	Борлуулалтын орлого	сая.төг	36,632.5	39,760.1	-3,127.6	41,097.4	41,134.2	-36.8	45,215.1	48,429.6	-3,214.5
		Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	1,479.6	963.0	516.6	1,467.5	1,603.4	-135.9	1,467.5	1,599.3	-131.8
3	Нийт зардал		сая.төг	40,510.9	39,777.3	733.6	42,564.9	42,144.2	420.7	52,806.7	49,968.4	2,838.3
4	Татварын өмнөх ашиг/алдагдал		сая.төг	-2,398.8	945.8	3,344.6	0.0	593.4	-593.4	-6,124.1	60.5	-6,184.6
5	Татварын дараах ашиг/алдагдал		сая.төг	-2,398.8	841.6	3,240.5	0.0	543.5	-543.5	-6,124.6	54.1	-6,178.7
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал		төг	1.06	0.98	0.1	1.00	0.99	0.0	1.13	1.00	0.1
7	Нийт авлага		сая.төг	7,357.8	3,307.2	4,050.6	5,511.3	3,584.3	1,926.9	6,429.0	5,709.1	719.9
8	Нийт өглөг		сая.төг	10,597.3	7,203.2	3,394.1	7,657.4	6,493.8	1,163.6	153,258.6	6,819.7	146,438.9
	Үүнээс:	Богино хугацаат өр төлбөр	сая.төг	10,597.3	7,203.2	3,394.1	2,140.0	1,024.3	1,115.7	5,781.7	2,712.9	3,068.8
		Урт хугацаат өр төлбөр	сая.төг	0.0	0.0	0.0	5,517.4	5,469.4	48.0	147,476.9	4,106.8	143,370.1
9	Нийт ажиллагсдын тоо		хүн	459.0	454.0	5.0	450.0	449.0	1.0	450.0	449.0	1.0
10	Нийт цалингийн сан		сая.төг	10,898.2	10,565.5	332.7	11,619.8	11,608.2	11.6	11,650.7	11,617.7	33.0
11	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт		сая.төг	5,381.8	3,945.9	1,435.9	5,575.9	4,385.1	1,190.8	7,092.9	5,163.3	1,929.6

5.2 Орхон АЗЗА ТӨХК-ийн техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлт

Д/д	Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2019		Зөрүү	2020		Зөрүү	2021		Зөрүү	
			Төл	Гүйц		Төл	Гүйц		Төл	Гүйц		
			х	1		2	3		4	5		6
1	Нийт орлого	сая.төг	985.5	1,080.9	-95.4	1,157.7	1,215.4	-57.7	1,337.5	1,200.3	137.2	
	Үүнээс:	Улсын чанартай АЗЗА	сая.төг	799.0	767.1	31.9	782.4	1,098.8	-316.4	1,121.0	978.1	142.9
		Бусад	сая.төг	186.5	313.8	-127.3	375.3	116.6	258.7	216.5	222.2	-5.7
2	Нийт зардал	сая.төг	962.8	1,058.2	-95.4	1,134.6	1,180.2	-45.6	1,284.4	1,198.0	86.4	
3	Татварын өмнөх ашиг/алдагдал	сая.төг	22.6	22.6	0.0	23.1	35.2	-12.1	53.1	2.3	50.8	
4	Татварын дараах ашиг/алдагдал	сая.төг	20.4	20.4	0.0	20.8	31.7	-10.9	47.8	20.7	27.1	
5	Шимтгэл татвар, хураамж, төлбөр	сая.төг	185.0	172.8	12.2	178.1	300.0	-121.9	266.3	254.3	12.0	
6	Төрийн өмчийн ногдол ашиг	сая.төг	0.00	0.97	-0.97	4.08	3.17	0.91	4.78	0.30	4.48	
7	Нийт авлага	сая.төг	171.0	182.1	-11.1	160.0	187.0	-27.0	176.8	168.7	8.1	
8	Нийт өглөг	сая.төг	756.9	756.9	0.0	726.9	751.0	-24.1	726.9	798.4	-71.5	
	Үүнээс:	Богино хугацаат өр төлбөр	сая.төг	130.0	130.0	0.0	100.0	124.1	-24.1	100.0	171.5	-71.5
		Урт хугацаат өр төлбөр	сая.төг	626.9	626.9	0.00	626.9	626.9	0.00	626.9	626.9	0.00
9	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.98	0.98	0.0	0.98	0.97	0.0	0.96	0.99	0.0	
10	Хөрөнгө оруулалт	сая.төг	10.7	10.0	0.7	8.0	8.0	0.0	25.4	10.4	15.0	
11	Нийт ажиллагсдын тоо	хүн	38.0	37.0	1.0	38.0	38.0	0.0	39.0	37.0	2.0	
12	Нийт цалингийн сан	сая.төг	359.3	326.7	32.6	406.0	413.2	-7.2	419.3	404.0	15.2	